



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

СТАТИСТИКИЙН БИЗНЕС РЕГИСТР | 2022

Салбарын танилцуулга

Улаанбаатар хот
2023

АГУУЛГА

| | |
|--|----|
| ТОВЧИЛСОН ҮГС..... | 2 |
| ОРШИЛ..... | 3 |
| ХУРААНГУЙ..... | 4 |
| НЭГ ДҮГЭЭР БҮЛЭГ..... | 5 |
| СТАТИСТИКИЙН БИЗНЕС РЕГИСТР..... | 5 |
| 1.1. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, АНГИЛАЛ..... | 5 |
| 1.2. БИЗНЕС РЕГИСТРИЙН МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, ӨӨРЧЛӨЛТ, ХӨДӨЛГӨӨН 8 | |
| ХОЁРДУГААР БҮЛЭГ..... | 12 |
| АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА..... | 12 |
| ГУРАВДУГААР БҮЛЭГ..... | 16 |
| ХУУЛИЙН ЭТГЭЭД..... | 16 |
| 3.1 ХУУЛИЙН ЭТГЭЭД, бүс, аймаг, нийслэлээр..... | 16 |
| 3.2. ХУУЛИЙН ЭТГЭЭД, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар..... | 18 |
| 3.3. ХУУЛИЙН ЭТГЭЭД, хариуцлагын хэлбэрээр..... | 23 |
| 3.4. ХУУЛИЙН ЭТГЭЭД, өмчийн хэлбэрээр..... | 24 |
| 3.5. ХУУЛИЙН ЭТГЭЭД, эдийн засгийн салбарын ангиллаар..... | 26 |
| ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ..... | 29 |
| ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ..... | 29 |
| 4.1 ХУУЛИЙН ЭТГЭЭД, ажиллагчдын тооны бүлгээр..... | 29 |
| 4.2 АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГО..... | 36 |
| ТАВДУГААР БҮЛЭГ..... | 41 |
| ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИД..... | 41 |
| ЗУРГААДУГААР БҮЛЭГ..... | 48 |
| ХОРШООНЫ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ..... | 48 |
| 6.1. ХОРШООНЫ ТОО, ТӨРӨЛ, БАЙРШИЛ..... | 48 |
| 6.2. ХОРШООНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ..... | 50 |
| ХАВСРАЛТ..... | 53 |

ТОВЧИЛСОН ҮГС

| | |
|--------|--|
| ААНБ | Аж ахуйн нэгж, байгууллага |
| ББН | Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл |
| ЗБН | Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл |
| ОНӨҮГ | Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар |
| СБР | Статистикийн бизнес регистр |
| ТБ | Төсвийн байгууллага |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТӨҮГ | Төрийн өмчит үйлдвэрийн газар |
| ТЕГ | Татварын ерөнхий газар |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| ХАА | Хөдөө аж ахуй |
| ХК | Хувьцаат компани |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ЭЗҮАСА | Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал |

ОРШИЛ

Үндэсний статистикийн хороо (ҮСХ) нь бизнес регистрийн өгөгдлийн санг 1998 онд анх байгуулж, бизнес регистрийн улирлын мэдээ, аж ахуйн нэгжийн 2006, 2011, 2016, 2021 онуудын тооллогын дүн, Улсын бүртгэлийн ерөнхий газрын (УБЕГ) болон Татварын ерөнхий газрын (ТЕГ) бүртгэл зэрэг бусад яам, агентлагийн мэдээлэлд үндэслэн тогтмол шинэчилж, эдийн засгийн бүхий л салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн салбар нэгжийн мэдээллийг бүртгэж байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоог тэдний эрхэлж байгаа ажил, үйлчилгээний чиглэл, байршлаар нь бодитой тогтоож, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг тодорхойлох, улмаар статистикийн судалгааны хамрах хүрээг тогтоох, түүвэр судалгаа явуулах, бусад мэдээллийн эх үүсвэртэй холбох, аж ахуйн нэгж, байгууллагын бүтцэд дүн шинжилгээ хийхэд бизнес регистр чухал үүрэгтэй.

ҮСХ нь аж ахуйн нэгж, байгууллагаас тэдний холбогдох мэдээллийг хүлээн авч, бизнес регистрийн өгөгдлийн санг бүрдүүлж, баяжуулан хэрэглэгчдэд Монгол Улсын “Статистикийн тухай” хуулинд заасан чиг үүргийн дагуу үйлчилдэг.

ХУРААНГУЙ

Сүүлийн жилүүдэд манай улсын аж ахуйн нэгж, байгууллагын хууль эрх зүй, бизнесийн орчин шинэчлэгдэж, аж ахуйн нэгж, байгууллагын бүтэц, цар хүрээ, үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт гарсаар байна. Иймд энэ чиглэлийн статистикийг бий болгон ашиглах, статистикийн мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх хэрэгцээ, шаардлага зайлшгүй гарч байна.

Үндэсний статистикийн хорооноос статистикийн бизнес регистрийн өгөгдлийн сан (БРӨС)-д үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагын байршил, үйл ажиллагааны чиглэл, хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэр, ажиллагчдын тооны бүлэг зэрэг үндсэн үзүүлэлтийг динамикаар харуулсан танилцуулгыг боловсрууллаа.

БРӨС-д 1998 онд 20.1 мянган хуулийн этгээд бүртгэлтэй байсан бол 2022 онд 248.8 мянгад хүрч, 1998 оноос 12.4 дахин нэмэгдсэн байна.

Нийт хуулийн этгээдийн 190.8 мянга (76.7%) нь Улаанбаатар хотод, 37.9 мянга (15.2%) нь Хангайн болон Төвийн бүсийн аймгуудад, 20.1 мянга (8.1%) нь Зүүн болон Баруун бүсийн аймгуудад байршилтай байна.

БРӨС-д бүртгэлтэй 248.8 мянган хуулийн этгээдийн 91.8 мянга (36.9%) нь үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаа явуулаагүй 157.0 мянган хуулийн этгээдийн 114.7 мянга (73.0%) нь үйл ажиллагаагаа түр зогсоосон бол үлдсэн 42.3 мянга (27.0%) нь үйл ажиллагаагаа эхлүүлээгүй эсвэл бүрэн зогсоосон, хөрөнгө санхүүгийн эх үүсвэр дутагдалтай, үйл ажиллагаа явуулах ажлын байргүй зэрэг шалтгаантай байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийг үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл үйлчилгээний салбарт 2022 онд хамгийн их буюу 37.4 мянган хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байгаа бол ХАА-н салбарт хамгийн бага буюу 3.5 мянган хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.**СТАТИСТИКИЙН БИЗНЕС РЕГИСТР**

БРӨС нь хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, эзэмшигч, харьяаллын хэлбэр, хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэр, өмчийн хувь, өмчийн харьяалах улс, үйл ажиллагааны чиглэл, үйл ажиллагаа явуулж буй хаяг, хөрөнгө, орлого, ажиллагчдын тоо, цалин зэрэг мэдээллийг агуулна.

1.1. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, АНГИЛАЛ**1.1.1 Ойлголт, тодорхойлолт**

Статистикийн нэгж: Албан ёсны статистикийн мэдээллийг цуглуулах нэгжийг хэлнэ.

Хуулийн этгээд: Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ /Иргэний хууль, 25.1 дахь заалт/.

Аж ахуйн нэгж : Хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болдог /Иргэний хууль, 25.2 дахь заалт/ бөгөөд ашгийн төлөө буюу бизнесийн зорилгоор үйл ажиллагаа явуулж байгаа нэгжүүдийг аж ахуйн нэгж гэж үзнэ.

Бие даасан хуулийн этгээд: Зөвхөн ганц орон нутгийн нэгжтэй хуулийн этгээдийг ойлгоно.

Толгой компани: Толгой буюу харьяалах дээд байгууллага нь аж ахуйн нэгжийн хэтийн болон цаг үеийн бодлого, төлөвлөгөө боловсруулан удирдамж, мэдээлэл, зааварчилгаа, зөвлөмжөөр хангадаг, санхүүгийн хувьд бие даасан хуулийн этгээд юм.

Охин компани: Компанийн нийт энгийн хувьцааны 51-ээс 100 хүртэл хувийг өөр /толгой/ компани дангаараа эзэмшдэг бие даасан хуулийн этгээдийг хэлнэ. Охин компани нь тусдаа санхүүгийн тайлан гаргахын зэрэгцээ толгой компанитайгаа нэгдсэн тайлан гаргана /"Компанийн тухай" Монгол улсын хуулийн 2-р бүлгийн 6-р зүйлийн 4-р хэсэгт зааснаар/

Хараат компани: Компанийн нийт энгийн хувьцааны 20-51 хүртэл хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хэлнэ. Хараат компани нь бие даасан тайлан баланс гаргадаг хуулийн этгээд байна /"Компанийн тухай" Монгол улсын хуулийн 2-р бүлгийн 6-р зүйлийн 5-р хэсэгт зааснаар/.

Салбар нэгж: Толгой компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг тусгай нэгж бөгөөд компанийн үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь, түүнчлэн төлөөлөгчийн газрын үүргийг гүйцэтгэж болно /"Компанийн тухай" Монгол улсын хуулийн 2-р бүлгийн 7-р зүйлийн 1-р хэсэгт зааснаар/. Салбарын охин/хараат компаниас ялгагдах онцлог нь хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй.

Төлөөлөгчийн газар: Компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг нэгж бөгөөд компанийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа явуулна.

Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг нэгж: Бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж, нөөцийг хуваарилдаг санхүүгийн болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах эрхтэй бие даасан хуулийн этгээдийг ойлгоно.

Орон нутгийн нэгж: Зөвхөн нэг байршилд, нэг төрлийн үйл ажиллагаа эрхэлж (туслах бус үйл ажиллагаа) байгаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг нэгж, эсвэл түүний нэг хэсгийг ойлгоно.

Хоршоо: Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.

Төрийн өмчит үйлдвэрийн газар, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар: Дан ганц төрийн болон орон нутгийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газрыг хэлнэ.

Төсөвт байгууллага: Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар гэнэ.

Төрийн бус байгууллага (Сууц өмчлөгчдийн холбоо): Нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий хуулийн этгээдийг холбоо гэнэ.

Сан: Нэг буюу хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай, нэгдмэл зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан гишүүнчлэлгүй хуулийн этгээдийг сан гэнэ.

Бусад: Энд олон улсын байгууллага, хувийн боловсрол сургалтын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, гадаадын хуулийн этгээд, төрийн бус байгууллагын төлөөний болон төлөөлөгчийн газар багтана.

Захиргааны регистр/бүртгэл (Administrative register): Захиргаа, хууль, татварын зорилгоор бий болгосон тухайн нутаг дэвсгэр дэх аж ахуйн нэгж, байгууллагыг байнга бүртгэж, шинэчилдэг захиргааны байгууллагын хөтөлдөг бүртгэлийг ойлгоно. Тухайлбал, ТЕГ нь аж ахуйн нэгж, байгууллагын татварын талаарх нарийвчилсан мэдээллийг бүртгэх зорилгоор татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийг хөтөлдөг.

Судалгааны хүрээ (Survey frame): Судалгааны хүрээ гэж тодорхой судалгаанд зориулан тайлант хугацаанд хадгалсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг нэгжийн жагсаалт байна.

1.1.2. Ангилал

БРӨС-гийн үзүүлэлтийг олон улсын зөвлөмж, төрийн захиргааны бусад байгууллагын захиргааны мэдээллийн санд мөрдөж буй албан ёсны ангилал, кодын дагуу ангилна. Үүнд:

- **Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код:** Стандартчилал, хэмжилзүйн газрын 2006 онд гаргасан “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код”
- **Монгол Улсын бүсчлэлийн код:** Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас 2013 онд гаргасан “Монгол Улсын бүсчлэлийн кодын лавлах”
- **Дэлхийн улс орон, нутаг дэвсгэрийн нэр, код:** Үндэсний Статистикийн Хорооны Даргын 2019 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн тушаалаар батлагдсан “Статистикийн зорилгоор ашиглах улс, нутаг дэвсгэрийн ангилал, код”
- **Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал:** Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319, А/160 тоот тушаалаар батлагдсан ангилал
- **Хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийн ангилал:** Үндэсний статистикийн хорооны дарга, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар /хуучин нэрээр/-ын дарга, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын хамтарсан 2021 оны 3-р сарын 18-ны өдрийн А/29 / А/24 / А/175 тушаалаар батлагдсан ангилал
- **Хуулийн этгээдийн өмчийн төрөл, хэлбэрийн ангилал:** Үндэсний статистикийн хорооны дарга, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар /хуучин нэрээр/-ын дарга, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын хамтарсан 2021 оны 3-р сарын 18-ны өдрийн А/29 / А/24 / А/175 тушаалаар батлагдсан ангилал

- **Төрийн бус байгууллагын чиг үүргийн ангилал:** ҮСХ-ны даргын 2011 оны 04-р сарын 14-ний өдрийн 01/55 тоот тушаалаар батлагдсан ангилал.
- **Эдийн засгийн секторын ангилал:** ҮСХ-ны даргын 2015 оны 02-р сарын 18-ны өдрийн А/26 тоот тушаалаар батлагдсан ангилал
- **Ашгийн бус байгууллагын үйл ажиллагааны ангилал:** ҮСХ-ны даргын 2021 оны 11-р сарын 23-ны өдрийн А/199 тоот тушаалаар батлагдсан ангилал

1.2. БИЗНЕС РЕГИСТРИЙН МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, ӨӨРЧЛӨЛТ, ХӨДӨЛГӨӨН

БРӨС-д аж ахуйн нэгж, байгууллагын ердийн болон шилжих хөдөлгөөн, өөрчлөлтийг албан ёсны статистик мэдээлэл болон захиргааны мэдээллийн эх үүсвэрийг ашиглан дараах байдлаар хөтөлдөг.

1.2.1. Албан ёсны статистикийн мэдээллийн эх үүсвэр, давтамж:

БРӨС-гийн үзүүлэлтүүдийн үнэн бодит байдлыг хянах, засварлах үндсэн эх үүсвэр нь албан ёсны статистикийн мэдээлэл юм. Албан ёсны статистикийн мэдээлэлд бизнес регистрийн улирлын мэдээ болон эдийн засгийн салбаруудын сар, улирал, жилийн мэдээ, тайлан, аж ахуйн нэгжийн тооллогыг хамруулна.

1.2.1.1. Бизнес регистрийн улирлын мэдээ-БР-1

БРӨС-д шинээр бүртгэгдэх аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар нэгж, төлөөлөгчийн газрын мэдээллийг нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтсийн бизнес регистр болон салбар хариуцсан ажилтнууд БР-1 маягтаар авч, 14 хоног тутам өгөгдлийн санд шинээр нэмж, тусгадаг.

1.2.1.2. Салбаруудын сар, улирал, жилийн мэдээ

ҮСХ-ны БРӨС хариуцсан үндэсний хариуцагч нь мэдээллийн технологийн ажилтантай хамтран салбаруудын статистикийн сар, улирал, жилийн ААНБ-ын мэдээ, тайланд хамрагдсан нэгжийн мэдээллийг БРӨС-тай харьцуулан шалгаж, холбогдох өөрчлөлтийг тусгадаг.

Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь эдийн засаг, нийгмийн статистикийн сар, улирал, жилийн аж ахуйн нэгж, байгууллагын мэдээ, тайланд хамрагдсан тохиолдолд БРӨС-д үйл ажиллагаа эрхлэлтийн байдлыг “Үйл ажиллагаа явуулж байгаа” төлвөөр бүртгэдэг.

Нэгээс олон төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг нэгж нь эдийн засаг, нийгмийн статистикийн сар, улирлын хэд хэдэн мэдээ тайланд хамрагдсан тохиолдолд салбар хариуцсан ажилтнууд хамтран статистикийн сар, улирлын мэдээний орлогын хэмжээнд нь үндэслэн аль салбарт оруулахыг шийдвэрлэдэг.

1.2.1.3. Бизнес регистрийн өөрчлөлт, хөдөлгөөний жилийн тодруулга

Бизнес регистрийн жилийн тодруулгыг нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтсийн орон нутгийн хариуцагч нар БРӨС-гийн үндэсний хариуцагчаас ирүүлсэн хүрээний дагуу хуулийн этгээдээс тодруулж, БРӨС-д баяжилтыг тусгадаг.

1.2.2. Захиргааны мэдээллийн эх үүсвэр, давтамж

1.2.2.1. Хуулийн этгээдийн бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллагын хуулийн этгээдийн мэдээллийн санд үндэслэн өөрчлөлт, шинэчлэлтийг дараах зарчмын дагуу тухай бүр хийж байна.

Шинээр бүртгэгдсэн нэгжийн хувьд:

Нэгдүгээрт: ҮСХ-ны ББТХ-ийн ажилтан, бизнес регистрийн программ хангамж хариуцсан ажилтантай хамтран хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд тухайн хугацаанд шинээр бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар нэгж, төлөөлөгчийн газрын мэдээллийг БРӨС-тай харьцуулан шалгаж, БРӨС-д шинээр бүртгэх нэгжийг тодорхойлно.

Хоёрдугаарт: Нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтэс нь БРӨС-д шинээр бүртгэгдэх аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар нэгж, төлөөлөгчийн газраас бизнес регистрийн 14 хоногийн мэдээний маягтаар мэдээллийг авч, дотоод сүлжээний (intranet) программ хангамжид тусгаж, ҮСХ-ны БР хариуцсан ажилтнууд мэдээллийг шалгаж, баталгаажуулан БРӨС-д өөрчлөлтийг тусгана.

Гуравдугаарт: Шинээр байгуулагдсан нэгжийг тодорхойлохдоо дараах шалгалтыг хийнэ. Үүнд:

- 1) **Регистрийн дугаараар шалгах:** Тухайн хугацаанд байгуулагдсан хуулийн этгээдийг урьдчилан тодорхойлж, нэгжийг регистрийн дугаараар БРӨС-д байгаа эсэхийг шалгах.
- 2) **Нэр, байршлаар нь шалгах:** Хоёр өөр регистрийн дугаартай аж ахуйн нэгж, байгууллага нь ижил нэртэйгээр нэг байршилд үйл ажиллагаа явуулж байгаа эсэх.
- 3) **Нэр, эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр нь шалгах:** Хоёр өөр регистрийн дугаартай хуулийн этгээд нь адил нэртэй, ижил төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа эсэх.

1.2.2.2. Татварын асуудал эрхэлсэн байгууллагын мэдээллийн санд үндэслэн өөрчлөлт, шинэчлэлтийг дараах зарчмын дагуу ҮСХ-ны ББТХ-ийн ажилтнууд хийнэ.

Үйл ажиллагаа эрхлэлтийн байдал: Үйл ажиллагаа эрхлэлтийн байдлыг “Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар”-ын мэдээлэлд үндэслэн дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

1) “Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар”-ын жилийн тайлан, Нэмэгдсэн өртгийн албан татварын сарын тайланд аль нэг сар, жилийн эцэст тайлагнасан тохиолдолд нэгжийн үйл ажиллагаа эрхлэлтийн байдлыг **үйл ажиллагаа явуулж байгаа** гэж үзнэ.

2) Улсын бүртгэлийн байгууллагад татан буугдахаар мэдэгдлээ өгсөн, татварын байгууллагын татвар төлөгчийн бүртгэлээс хассан жагсаалтад орсон тохиолдолд үйл ажиллагаа эрхлэлтийн байдлыг **үйл ажиллагаа бүрэн зогссон** гэж үзнэ.


Орлого: “Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар”, “Санхүүгийн тайлан”-д тайлант оны 4-р улиралд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын орлогын хэмжээг ҮСХ-ны ББТХ-ийн ажилтан тайланг эцэслэн ирүүлснээс хойш 30 хоногийн дотор БРӨС-д тусгадаг.

1.2.2.3. **Ажиллагчдын тоо:** ТЕГ-ын “Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татвар ТТ-11” улирлын тайланд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын тайлант оны 4 улирлын ажиллагчдын тооны дунджаар авч БРӨС, НДЕГ-ын тайлантай уялдуулан шалгаж, эцэслэн ирүүлснээс хойш 30 хоногийн дотор засварладаг.

1.2.2.4. **Хөрөнгө, хөрөнгө оруулалт:** Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээллийн санд үндэслэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын хэмжээг дараа оны 5-р сарын 20-ны дотор БРӨС-д тусгадаг.

1.2.2.5. **Хоршооны үзүүлэлт:** Хоршооны гишүүний оруулсан хувь хөрөнгийн хэмжээ, гишүүдийн тоог Хуулийн этгээдийн бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллагын Хуулийн этгээдийн бүртгэл, Санхүүгийн зохицуулах хорооны Хадгаламж, зээлийн хоршооны мэдээлэлтэй тулгаж БРӨС-гийн мэдээлэлтэй харьцуулан шалгаж, тусгадаг.

1.2.2.6. **Төрийн захиргааны бусад байгууллагын мэдээлэл:** Хуулийн этгээдийн мэдээллийн сан бүхий төрийн захиргааны бусад байгууллагын мэдээллийг БРӨС-тай холбож, мэдээллийн чанарыг сайжруулж, сангийн үзүүлэлтүүдийг баяжуулж, шинэчилдэг.




ХОЁРДУГААР БҮЛЭГ.

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

ХОЁРДУГААР БҮЛЭГ.
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА


БРӨС-д бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо 2022 онд 253.4 мянга болж, өмнөх оны дүнгээс 19.3 мянга (8.3%)-аар, 2020 оноос 45.0 мянга (21.6%)-аар, 2019 оноос 61.2 мянга (31.8%)-аар, 2018 оноос 78.9 мянга (45.2%)-аар тус тус нэмэгджээ.

ЗУРАГ 2.1. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, жил бүрийн эцэст



Аж ахуйн нэгж, байгууллага нь охин, хараат компани, салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах замаар үйл ажиллагаагаа өргөжүүлдэг. БРӨС-д 2022 онд бүртгэлтэй 253.4 мянган аж ахуйн нэгж, байгууллагын 247.1 мянга (97.5%) нь бие даасан, 709 (0.3%) нь толгой компани, 1.0 мянга (0.4%) нь охин/хараат компани, 4.6 мянга (1.8%) нь салбар нэгж байна.

ЗУРАГ 2.2. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, харьяаллын хэлбэрээр, 2022 он




Бие даасан, толгой, охин/хараат аж ахуйн нэгж, байгууллагыг хуулийн этгээд гэж үзэх ба бизнес регистрийн өгөгдлийн санд 248.8 мянган хуулийн этгээд бүртгэлтэй байгаа нь нийт аж ахуйн нэгж, байгууллагын 98.2 хувийг эзэлж байна.

БРӨС-д 2022 оны жилийн эцэст 206.4 мянган аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаа нь нийт хуулийн этгээдийн 83.0 хувийг эзэлж байна. Нийт аж ахуйн нэгжийн 79.8 мянга (38.7%) нь үйл ажиллагаа явуулж байна.

Бие даасан аж ахуйн нэгж, байгууллагын 76.6 хувь нь Улаанбаатар хотод, 8.3 хувь нь Төвийн бүсэд, 7.0 хувь нь Хангайн бүсэд, 5.3 хувь нь Баруун бүсэд, 2.8 хувь нь Зүүн бүсэд байрлаж байна.

ХҮСНЭГТ 2.1. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, бүс, харьяаллын хэлбэрээр, 2022 он

| Бүс | Бүгд | Хэлбэр | | | |
|-------------|----------------|----------------|------------|--------------|--------------|
| | | Бие даасан | Толгой | Охин, хараат | Салбар |
| БҮГД | 253 407 | 247 095 | 709 | 1 027 | 4 576 |
| Баруун | 13 728 | 13 077 | 14 | 32 | 605 |
| Хангайн | 18 253 | 17 327 | 34 | 32 | 860 |
| Төвийн | 21 889 | 20 428 | 34 | 73 | 1 354 |
| Зүүн | 7 307 | 6 934 | 9 | 5 | 359 |
| Улаанбаатар | 192 230 | 189 329 | 618 | 885 | 1 398 |



ГУРАВДУГААР БҮЛЭГ.

ХУУЛИЙН ЭТГЭЭД

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

ХУУЛИЙН ЭТГЭЭД

3.1 ХУУЛИЙН ЭТГЭЭД, бүс, аймаг, нийслэлээр

Хуулийн этгээдийн төвлөрөл нь засаг захиргаа, байгаль, цаг уурын нөхцөл, газар зүйн онцлог, хүн амын шилжих хөдөлгөөн, хүн амын нягтрал зэрэг үзүүлэлтээс шалтгаалан газар зүйн бүс нутгаар нэлээд ялгаатай байдаг. Улаанбаатар хот болон Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Өмнөговь аймгуудад хуулийн этгээдийн төвлөрөл ихтэй байна (Хүснэгт 3.1, Зураг 3.1).

Улаанбаатар хотод 2018 онд нийт хуулийн этгээдийн 74.5 хувь нь байсан бол 2022 онд 76.7 хувь болж, 2.2 нэгж хувиар нэмэгджээ. Хуулийн этгээдийн нийт дүнд Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн хуулийн этгээдийн эзлэх хувь 2022 онд 2018 оноос 0.3-0.4 нэгж хувиар буурсан байна.


ХҮСНЭГТ 3.1. ХУУЛИЙН ЭТГЭЭД, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн эцэст

| Бүс, аймаг, нийслэл | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---------------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|
| БҮГД | 172 466 | 189 801 | 206 207 | 230 608 | 248 831 |
| Баруун бүс | 9 856 | 10 428 | 11 070 | 12 084 | 13 123 |
| Баян-Өлгий | 1 963 | 2 056 | 2 140 | 2 376 | 2 541 |
| Говь-Алтай | 1 153 | 1 212 | 1 290 | 1 410 | 1 554 |
| Завхан | 2 050 | 2 164 | 2 271 | 2 425 | 2 665 |
| Увс | 2 026 | 2 171 | 2 290 | 2 426 | 2 559 |
| Ховд | 2 664 | 2 825 | 3 079 | 3 447 | 3 804 |
| Хангайн бүс | 13 704 | 14 443 | 15 167 | 16 206 | 17 393 |
| Архангай | 1 548 | 1 649 | 1 636 | 1 760 | 1 920 |
| Баянхонгор | 1 797 | 1 939 | 2 101 | 2 288 | 2 491 |
| Булган | 1 540 | 1 621 | 1 726 | 1 853 | 2 011 |
| Орхон | 4 596 | 4 812 | 5 065 | 5 384 | 5 663 |
| Өвөрхангай | 1 908 | 2 016 | 2 121 | 2 250 | 2 431 |
| Хөвсгөл | 2 315 | 2 406 | 2 518 | 2 671 | 2 877 |
| Төвийн бүс | 15 369 | 16 476 | 17 633 | 18 915 | 20 535 |
| Говьсүмбэр | 472 | 494 | 559 | 594 | 637 |
| Дархан-Уул | 3 955 | 4 192 | 4 455 | 4 687 | 4 939 |
| Дорноговь | 1 607 | 1 767 | 1 942 | 2 118 | 2 324 |
| Дундговь | 1 064 | 1 124 | 1 174 | 1 228 | 1 336 |
| Өмнөговь | 2 660 | 2 942 | 3 238 | 3 650 | 4 064 |
| Сэлэнгэ | 3 379 | 3 569 | 3 721 | 3 911 | 4 152 |
| Төв | 2 232 | 2 388 | 2 544 | 2 727 | 3 083 |
| Зүүн бүс | 5 072 | 5 514 | 5 957 | 6 421 | 6 948 |
| Дорнод | 2 210 | 2 377 | 2 525 | 2 707 | 2 945 |
| Сүхбаатар | 1 059 | 1 130 | 1 199 | 1 282 | 1 391 |
| Хэнтий | 1 803 | 2 007 | 2 233 | 2 432 | 2 612 |
| Улаанбаатар | 128 465 | 142 940 | 156 380 | 176 982 | 190 832 |

Нийт 248.8 мянган хуулийн этгээдийн 190.8 мянга нь Улаанбаатар хотод бүртгэлтэй байгаа нь хамгийн их нягтралтай байна. Мөн Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Өмнөговь аймгуудад 4.1-5.7 мянган хуулийн этгээд байршиж байгаа нь хуулийн этгээдийн


тоогоор нягтрал ихтэй аймагт багтаж байна. Харин Говьсүмбэр (637), Дундговь (1336), Сүхбаатар (1391) аймгууд нь хуулийн этгээдийн тоогоор нягтрал багатай буюу хамгийн цөөхөн хуулийн этгээдтэй байна.

ЗУРАГ 3.1. ХУУЛИЙН ЭТГЭЭД, аймаг, нийслэлээр, 2022 он



Улаанбаатар хотын Баянзүрх (44.7 мянга), Баянгол (37.9 мянга), Сүхбаатар (34.5 мянга) дүүрэгт хамгийн их хуулийн этгээд бүртгэлтэй байгаа нь өндөр нягтралтай байна.


ЗУРАГ 3.2. ХУУЛИЙН ЭТГЭЭД, дүүргээр, 2022 он



Хуулийн этгээдийн тоогоор хамгийн бага аймгууд болох Говьсүмбэр, Дундговь,

Сүхбаатар, Говь-Алтай зэрэг аймгууд мөн хүн амын нягтралаар хамгийн сийрэг байна.

ЗУРАГ 3.3. ХУУЛИЙН ЭТГЭЭД, ХҮН АМЫН ТОО, бүсээр, 2022 он




3.2. ХУУЛИЙН ЭТГЭЭД, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар

Хуулийн этгээдийн үйл ажиллагаа эрхлэлтийн байдал нь статистикийн нэгжийг тодорхойлох чухал үзүүлэлтийн нэг юм. Хуулийн этгээдийн үйл ажиллагаа эрхлэлтийн байдлыг үйл ажиллагаа явуулж байгаа, үйл ажиллагаа эхлээгүй, түр зогсоосон, бүрэн зогсоосон, бусад гэсэн шалтгаанаар бүртгэдэг.

Нийт 248.8 мянган хуулийн этгээдийн 91.8 мянга буюу 36.9 хувь нь 2022 онд үйл ажиллагаагаа явуулж, харин 157.0 мянга буюу 63.1 хувь нь үйл ажиллагаагаа тодорхой шалтгаанаар явуулаагүй байна.

ЗУРАГ 3.4. ХУУЛИЙН ЭТГЭЭД, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар, жил бүрийн эцэст



Үйл ажиллагаа явуулж байгаа 91.8 мянган хуулийн этгээдийн 65.2 мянга (71.0%) нь Улаанбаатар хотод, 9.1 мянга (10.0%) нь Төвийн бүсэд, 7.9 мянга (8.6%) нь Хангайн бүсэд байна.

ХҮСНЭГТ 3.2. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭД, бүсээр, жил бүрийн эцэст

| Бүс | 2018 | | 2019 | | 2020 | | 2021 | | 2022 | |
|-------------|---------------|--------------|---------------|--------------|---------------|--------------|---------------|--------------|---------------|--------------|
| | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % |
| БҮГД | 71 716 | 100.0 | 75 522 | 100.0 | 76 329 | 100.0 | 81 533 | 100.0 | 91 811 | 100.0 |
| Баруун | 6 629 | 9.2 | 6 589 | 8.7 | 6 231 | 8.2 | 6 042 | 7.4 | 6 311 | 6.9 |
| Хангайн | 7 970 | 11.1 | 8 185 | 10.8 | 7 328 | 9.6 | 7 158 | 8.8 | 7 854 | 8.6 |
| Төвийн | 8 756 | 12.2 | 8 731 | 11.6 | 8 305 | 10.9 | 8 325 | 10.2 | 9 143 | 10.0 |
| Зүүн | 2 903 | 4.0 | 3 123 | 4.1 | 2 874 | 3.8 | 2 951 | 3.6 | 3 283 | 3.6 |
| Улаанбаатар | 45 458 | 63.4 | 48 894 | 64.7 | 51 591 | 67.6 | 57 057 | 70.0 | 65 220 | 71.0 |


Үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн 83.0 хувь нь компани, 6.9 хувь нь төрийн бус байгууллага, 5.3 хувь нь төсвийн байгууллага, 1.7 хувь нь нөхөрлөл байгаа бол өмчийн хэлбэрийн хувьд Монгол Улсын иргэний хувийн хуулийн этгээд 90.9 хувийг бүрдүүлж байна.

ХҮСНЭГТ 3.3. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭД, хариуцлагын хэлбэрээр, жил бүрийн эцэст

| Хариуцлагын хэлбэр | 2018 | | 2019 | | 2020 | | 2021 | | 2022 | |
|---------------------|---------------|--------------|---------------|--------------|---------------|--------------|---------------|--------------|---------------|--------------|
| | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % |
| БҮГД | 71 716 | 100.0 | 75 522 | 100.0 | 76 329 | 100.0 | 81 533 | 100.0 | 91 811 | 100.0 |
| Компани | 54 976 | 76.7 | 58 012 | 76.8 | 59 954 | 78.5 | 63 492 | 77.9 | 76 230 | 83.0 |
| Хоршоо | 2 308 | 3.2 | 2 063 | 2.7 | 1 700 | 2.2 | 1 402 | 1.7 | 1 584 | 1.7 |
| Нөхөрлөл | 1 862 | 2.6 | 1 799 | 2.4 | 1 532 | 2.0 | 1 431 | 1.8 | 1 570 | 1.7 |
| ТӨҮГ, ОНӨҮГ | 370 | 0.5 | 370 | 0.5 | 343 | 0.4 | 395 | 0.5 | 452 | 0.5 |
| Төсвийн байгууллага | 4 465 | 6.2 | 4 579 | 6.1 | 4 674 | 6.1 | 4 791 | 5.9 | 4 896 | 5.3 |
| ТББ | 7 580 | 10.6 | 8 571 | 11.3 | 7 755 | 10.2 | 9 552 | 11.7 | 6 380 | 6.9 |
| Бусад | 155 | 0.2 | 128 | 0.2 | 371 | 0.5 | 470 | 0.6 | 699 | 0.8 |


Үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийг үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл, хуулийн этгээдийн 37.4 мянга (40.7%) нь үйлчилгээний, 35.6 мянга (38.7%) нь худалдааны, 8.0 мянга (8.7%) нь аж үйлдвэрийн, 7.7 мянга (8.4%) нь барилгын, 3.2 мянга (3.4%) нь ХАА-н чиглэлийнх байна.

ЗУРАГ 3.5. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭД, үйл ажиллагааны чиглэл, жил бүрийн эцэст



Үйл ажиллагаа явуулаагүй хуулийн этгээдийн хувьд үйл ажиллагаагаа бүрэн болон түр зогсоосон хуулийн этгээдийн эзлэх хувь 2022 онд өмнөх оноос буурсан бол харин үйл ажиллагаа эхлээгүй шалтгаантай хуулийн этгээдийн эзлэх хувь нэмэгдсэн байна.

ЗУРАГ 3.6. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД, үйл ажиллагаа явуулаагүй шалтгаанаар, жил бүрийн эцэст



Үйл ажиллагаа явуулаагүй хуулийн этгээдийн тоо 2021 оноос 5.3 хувиар нэмэгдсэн нь үйл ажиллагаа эхлээгүй нэгжийн тоо 25.4 хувиар, бусад шалтгаантай нэгжийн тоо 0.7 хувиар, үйл ажиллагаа түр зогсоосон нэгжийн тоо 0.2 хувиар өссөнтэй холбоотой байна. Харин үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон нэгжийн тоо 1.8 хувиар буурчээ.

ХҮСНЭГТ 3.4. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД, үйл ажиллагаа явуулаагүй шалтгаанаар, жил бүрийн эцэст

| Шалтгаан | 2019 | | 2020 | | 2021 | | 2022 | |
|-------------------------------|----------------|--------------|----------------|--------------|----------------|--------------|----------------|--------------|
| | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % |
| БҮГД | 114 279 | 100.0 | 129 878 | 100.0 | 149 075 | 100.0 | 157 020 | 100.0 |
| Үйл ажиллагаа эхлээгүй | 26 979 | 23.6 | 26 312 | 20.3 | 30 441 | 20.4 | 38 162 | 24.3 |
| Үйл ажиллагаа түр зогсоосон | 83 943 | 73.5 | 100 210 | 77.2 | 114 429 | 76.8 | 114 691 | 73.0 |
| Үйл ажиллагаа бүрэн зогсоосон | 1 713 | 1.5 | 1 930 | 1.5 | 2 676 | 1.8 | 2 627 | 1.7 |
| Бусад | 1 644 | 1.4 | 1 426 | 1.1 | 1 529 | 1.0 | 1 540 | 1.0 |

2022 онд үйл ажиллагаа явуулаагүй 157.0 мянган хуулийн этгээдийн 38.2 мянга (24.3%) нь үйл ажиллагаагаа эхлээгүй, 114.7 мянга (73.0%) нь үйл ажиллагаагаа түр зогсоосон, 2.6 мянга (1.7%) нь үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон, 1.5 мянга (1.0%)

нь бусад шалтгаантай байна.

Үйл ажиллагаагаа эхлээгүй болон бусад шалтгаанаар үйл ажиллагаагаа явуулаагүй хуулийн этгээдийн 90.0-ээс дээш хувь нь Улаанбаатарт байгаа бол үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон хуулийн этгээдийн 57.6 хувь нь Улаанбаатарт, 18.3 хувь нь Хангайн бүсэд, 12.0 хувь нь Баруун бүсэд, 8.9 хувь нь Төвийн бүсэд, 3.2 хувь нь Зүүн бүсэд байна.

ХҮСНЭГТ 3.5. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД, бүс, үйл ажиллагаа явуулаагүй шалтгаанаар, 2022 он

| Бүс | БҮГД | Үйл ажиллагаа эрхлээгүй шалтгаан | | | | | | | |
|-------------|----------------|----------------------------------|--------------|----------------|--------------|-----------------|--------------|--------------|--------------|
| | | эхлээгүй | | түр зогсоосон | | бүрэн зогсоосон | | бусад | |
| | | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % |
| БҮГД | 157 020 | 38 162 | 100.0 | 114 691 | 100.0 | 2 627 | 100.0 | 1 540 | 100.0 |
| Баруун | 6 812 | 787 | 2.1 | 5 700 | 5.0 | 315 | 12.0 | 10 | 0.6 |
| Хангайн | 9 539 | 985 | 2.6 | 8 042 | 7.0 | 481 | 18.3 | 31 | 2.0 |
| Төвийн | 11 392 | 1 608 | 4.2 | 9 467 | 8.3 | 233 | 8.9 | 84 | 5.5 |
| Зүүн | 3 665 | 350 | 0.9 | 3 221 | 2.8 | 85 | 3.2 | 9 | 0.6 |
| Улаанбаатар | 125 612 | 34 432 | 90.2 | 88 261 | 77.0 | 1 513 | 57.6 | 1 406 | 91.3 |

Үйл ажиллагаа явуулаагүй нийт 157.0 мянган хуулийн этгээдийн дийлэнх буюу 118.9 мянга (75.7%) нь компани байна.


ХҮСНЭГТ 3.6. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД, хариуцлагын хэлбэр, үйл ажиллагаа явуулаагүй шалтгаанаар, 2022 он

| Хариуцлагын хэлбэр | БҮГД | Үйл ажиллагаа эрхлээгүй шалтгаан | | | | | | | |
|------------------------|----------------|----------------------------------|--------------|----------------|--------------|-----------------|--------------|--------------|--------------|
| | | эхлээгүй | | түр зогсоосон | | бүрэн зогсоосон | | бусад | |
| | | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % |
| БҮГД | 157 020 | 38 162 | 100.0 | 114 691 | 100.0 | 2 627 | 100.0 | 1 540 | 100.0 |
| Компани | 118 873 | 29 534 | 77.4 | 86 405 | 75.3 | 1 540 | 58.6 | 1 394 | 90.5 |
| Хоршоо | 3 497 | 362 | 0.9 | 2 892 | 2.5 | 221 | 8.4 | 22 | 1.4 |
| Нөхөрлөл | 4 158 | 644 | 1.7 | 3 384 | 3.0 | 105 | 4.0 | 25 | 1.6 |
| ТӨҮГ, ОНӨҮГ | 85 | 3 | 0.0 | 69 | 0.1 | 13 | 0.5 | - | - |
| Төсвийн байгууллага | 6 | 1 | 0.0 | 3 | 0.0 | 2 | 0.1 | - | - |
| Төрийн бус байгууллага | 28 932 | 7 296 | 19.1 | 20 876 | 18.2 | 692 | 26.3 | 68 | 4.4 |
| Бусад | 1 469 | 322 | 0.8 | 1 062 | 0.9 | 54 | 2.1 | 31 | 2.0 |

Үйл ажиллагаа явуулаагүй хуулийн этгээдийг үйл ажиллагааны чиглэлээр авч

үзвэл, 42.5 хувь нь үйлчилгээний, 37.8 хувь нь худалдааны, 7.7 хувь нь аж үйлдвэрийн, 7.0 хувь нь барилгын, 5.0 хувь нь хөдөө аж ахуйн салбарт байна.

ЗУРАГ 3.7. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД, үйл ажиллагааны чиглэл, үйл ажиллагаа явуулаагүй шалтгаанаар, 2022 он



3.3. ХУУЛИЙН ЭТГЭЭД, хариуцлагын хэлбэрээр

Хуулийн этгээдийг хариуцлагын хэлбэрийн хувьд бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл (ББН), зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл (ЗБН), хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл (ХХН), хоршоо, хувьцаат компани (ХК), хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК), төрийн өмчит үйлдвэрийн газар (ТӨҮГ), орон нутгийн өмчит үйлдвэрийн газар (ОНӨҮГ), төсвийн байгууллага (ТБ), төрийн бус байгууллага (ТББ) болон бусад гэж ангилдаг. Бусад төрлийн ангилалд хувийн сургууль, эмнэлэг, сонин, хэвлэлийн газар гэх мэт хариуцлагын хэлбэрээр ангилах боломжгүй нэгжүүдийг хамруулна.

БРӨС-д 2022 онд бүртгэлтэй хуулийн этгээдийг хариуцлагын хэлбэрээр авч үзвэл, компани 195.1 мянга буюу 78.4 хувь, төрийн бус байгууллага 35.3 мянга буюу 14.2 хувь, нөхөрлөл 5.7 мянга буюу 2.3 хувь, хоршоо 5.1 мянга буюу 2.0 хувь, төсвийн байгууллага 4.9 мянга буюу 2.0 хувь, ТӨҮГ, ОНӨҮГ 537 буюу 0.2 хувь, бусад төрлийн нэгж 2.2 мянга буюу 0.9 хувийг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 3.7. ХУУЛИЙН ЭТГЭЭД, хариуцлагын хэлбэрээр, жил бүрийн эцэст

| Хариуцлагын хэлбэр | 2019 | | 2020 | | 2021 | | 2022 | |
|---------------------|----------------|--------------|----------------|--------------|----------------|--------------|----------------|--------------|
| | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % |
| БҮГД | 189 801 | 100.0 | 206 207 | 100.0 | 230 608 | 100.0 | 248 831 | 100.0 |
| Компани | 151 289 | 79.7 | 163 057 | 79.1 | 179 772 | 78.0 | 195 103 | 78.4 |
| Хоршоо | 4 605 | 2.4 | 4 533 | 2.2 | 4 677 | 2.0 | 5 081 | 2.0 |
| Нөхөрлөл | 4 869 | 2.6 | 5 126 | 2.5 | 5 467 | 2.4 | 5 728 | 2.3 |
| ТӨҮГ, ОНӨҮГ | 459 | 0.2 | 472 | 0.2 | 507 | 0.2 | 537 | 0.2 |
| Төсвийн байгууллага | 4 599 | 2.4 | 4 684 | 2.3 | 4 824 | 2.1 | 4 902 | 2.0 |
| ТББ | 22 632 | 11.9 | 26 779 | 13.0 | 33 254 | 14.4 | 35 312 | 14.2 |
| Бусад | 1 348 | 0.7 | 1 556 | 0.8 | 2 107 | 0.9 | 2 168 | 0.9 |

Хуулийн этгээдийн тоог хариуцлагын хэлбэр, бүсээр авч үзвэл, компанийн хувьд дийлэнх буюу 76.7 хувь нь Улаанбаатар хотод байгаа бол 20.5 мянга буюу 8.3 хувь нь Төвийн бүсэд, 17.4 мянга буюу 7.0 хувь нь Хангайн бүсэд, 13.1 мянга буюу 5.3 хувь нь Баруун бүсэд, 6.9 мянга буюу 2.8 хувь нь Зүүн бүсэд байршиж байна.

ХҮСНЭГТ 3.8. ХУУЛИЙН ЭТГЭЭД, хариуцлагын хэлбэр, бүсээр, 2022 он

| Хариуцлагын хэлбэр | БҮГД | Бүс | | | | |
|---------------------|----------------|---------------|---------------|---------------|--------------|----------------|
| | | Баруун | Хангайн | Төвийн | Зүүн | Улаанбаатар |
| БҮГД | 248 831 | 13 123 | 17 393 | 20 535 | 6 948 | 190 832 |
| Компани | 195 103 | 7 594 | 10 958 | 13 583 | 4 334 | 158 634 |
| Хоршоо | 5 081 | 1 502 | 1 346 | 996 | 352 | 885 |
| Нөхөрлөл | 5 728 | 980 | 916 | 1 497 | 497 | 1 838 |
| ТӨҮГ, ОНӨҮГ | 537 | 70 | 98 | 144 | 61 | 164 |
| Төсвийн байгууллага | 4 902 | 985 | 1 104 | 1 143 | 495 | 1 175 |
| ТББ | 35 312 | 1 962 | 2 909 | 3 121 | 1 176 | 26 144 |
| Бусад | 2 168 | 30 | 62 | 51 | 33 | 1 992 |


3.4. ХУУЛИЙН ЭТГЭЭД, өмчийн хэлбэрээр

Хуулийн этгээдийг өмчийн төрлөөр нь төрийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой, төрийн өмчийн хамтарсан; орон нутгийн өмчийн, орон нутгийн өмчийн оролцоотой, орон нутгийн өмчийн хамтарсан; Монгол Улсын иргэний хувийн өмчийн, гадаадын иргэнтэй хамтарсан, гадаад улсын гэж ангилна.

Нийт хуулийн этгээдийн 234.1 мянга (94.1%) нь Монгол Улсын иргэний хувийн хуулийн этгээд, 5.5 мянга (2.2%) нь төрийн болон орон нутгийн өмчийн, 6.9 мянга (2.8%) нь гадаад улсын өмчийн, 2.4 мянга (1.0%) нь хувийн гадаадтай хамтарсан

хуулийн этгээд байна.

ЗУРАГ 3.8. ХУУЛИЙН ЭТГЭЭД, өмчийн хэлбэрээр, 2022 он



Монгол Улсын иргэний хувийн хуулийн этгээдийн 190.8 мянга буюу 76.7 хувь нь Улаанбаатар хотод, 20.5 мянга буюу 8.3 хувь нь Төвийн бүсэд, 17.4 мянга буюу 7.0 хувь нь Хангайн бүсэд, 13.1 мянга буюу 5.3 хувь нь Баруун бүсэд, 6.9 мянга буюу 2.8 хувь нь Зүүн бүсэд байршиж байна.

Улаанбаатар хотын 190.0 мянган хуулийн этгээдийн 94.6 хувь нь Монгол Улсын иргэний хувийн, 3.5 хувь нь гадаад улсын, 1.2 хувь нь гадаадтай хамтарсан, 0.7 хувь нь төрийн болон орон нутгийн өмчийн нэгж байна.

Гадаад улсын эзэмшлийн хуулийн этгээдийн 97.6 хувь нь Улаанбаатар хотод, 1.4 хувь нь Төвийн бүсэд, 0.5 хувь нь Хангайн бүсэд, 0.3 хувь нь Зүүн бүсэд, 0.2 хувь нь Баруун бүсэд байна.

ХҮСНЭГТ 3.9. ХУУЛИЙН ЭТГЭЭД, өмчийн хэлбэр, бүсээр, 2022 он

| Өмчийн хэлбэр | БҮГД | Бүс | | | | |
|----------------------------------|----------------|---------------|---------------|---------------|--------------|----------------|
| | | Баруун | Хангайн | Төвийн | Зүүн | Улаанбаатар |
| БҮГД | 248 831 | 13 123 | 17 393 | 20 535 | 6 948 | 190 832 |
| Төрийн болон орон нутгийн өмчийн | 5 546 | 1 065 | 1 231 | 1 308 | 560 | 1 382 |
| Монгол Улсын иргэний хувийн | 234 057 | 12 007 | 16 111 | 19 086 | 6 347 | 180 506 |
| Хувийн гадаадтай хамтарсан | 2 377 | 37 | 19 | 46 | 19 | 2 256 |
| Гадаад улсын | 6 851 | 14 | 32 | 95 | 22 | 6 688 |

Хуулийн этгээдийн тоог үйл ажиллагааны чиглэл, өмчийн хэлбэрээр авч үзвэл, Монгол Улсын иргэний хувийн өмчийн хуулийн этгээдийн 41.4 хувь нь үйлчилгээний салбарт, 38.1 хувь нь худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бол гадаад улсын хуулийн этгээдийн 62.0 хувь нь худалдааны салбарт, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн 92.0 хувь нь үйлчилгээний салбарт, хувийн гадаадтай хамтарсан хуулийн этгээдийн 59.3 хувь нь худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ 3.10. ХУУЛИЙН ЭТГЭЭД, үйл ажиллагааны чиглэл, өмчийн хэлбэрээр, 2022 он

| Үйл ажиллагааны чиглэл | БҮГД | | Өмчийн хэлбэр | | | | | | | |
|------------------------|----------------|--------------|----------------------------------|--------------|-----------------------------|--------------|----------------------------|--------------|--------------|--------------|
| | | | Төрийн болон орон нутгийн өмчийн | | Монгол Улсын иргэний хувийн | | Хувийн гадаадтай хамтарсан | | Гадаад улсын | |
| | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % |
| БҮГД | 248 831 | 100.0 | 5 546 | 100.0 | 234 057 | 100.0 | 2 377 | 100.0 | 6 851 | 100.0 |
| ХАА | 11 086 | 4.5 | 74 | 1.3 | 10 910 | 4.7 | 35 | 1.5 | 67 | 1.0 |
| Аж үйлдвэр | 20 055 | 8.1 | 262 | 4.7 | 18 973 | 8.1 | 255 | 10.7 | 565 | 8.2 |
| Барилга | 18 616 | 7.5 | 39 | 0.7 | 18 054 | 7.7 | 164 | 6.9 | 359 | 5.2 |
| Худалдаа | 94 948 | 38.2 | 66 | 1.2 | 89 222 | 38.1 | 1 410 | 59.3 | 4 250 | 62.0 |
| Үйлчилгээ | 104 126 | 41.8 | 5 105 | 92.0 | 96 898 | 41.4 | 513 | 21.6 | 1 610 | 23.5 |

3.5. ХУУЛИЙН ЭТГЭЭД, эдийн засгийн салбарын ангиллаар

БРӨС-д хуулийн этгээд, түүний салбар нэгжийг эдийн засгийн бүх төрлийн салбарын ангилал 3.0, 3.1, 4.0, 4.1 хувилбаруудаар бүртгэдэг бөгөөд энэхүү танилцуулгад Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319, А/160 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал” (ISIC) хувилбар 4.1-ийн дагуу тоо, мэдээллийг гаргалаа.


2022 оны байдлаар бүртгэлтэй хуулийн этгээдийн 38.2 хувь нь худалдаа, 7.5 хувь нь барилга, 6.5 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт байна.

ХҮСНЭГТ 3.11. ХУУЛИЙН ЭТГЭЭД, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, жил бүрийн эцэст

| Салбар | 2019 | | 2020 | | 2021 | | 2022 | |
|---|----------------|--------------|----------------|--------------|----------------|--------------|----------------|--------------|
| | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % |
| БҮГД | 189 801 | 100.0 | 206 207 | 100.0 | 230 608 | 100.0 | 248 831 | 100.0 |
| Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур | 8 499 | 4.5 | 9 171 | 4.4 | 9 975 | 4.3 | 11 086 | 4.5 |

СТАТИСТИКИЙН БИЗНЕС РЕГИСТРИЙН ТАНИЛЦУУЛГА – 2022

| | | | | | | | | |
|---|--------|------|--------|------|--------|------|--------|------|
| Уул уурхай, олборлолт | 2 765 | 1.5 | 2 865 | 1.4 | 2 964 | 1.3 | 3 072 | 1.2 |
| Боловсруулах үйлдвэрлэл | 12 506 | 6.6 | 13 660 | 6.6 | 14 876 | 6.5 | 16 217 | 6.5 |
| Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж | 358 | 0.2 | 356 | 0.2 | 357 | 0.2 | 365 | 0.1 |
| Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа | 313 | 0.2 | 327 | 0.2 | 357 | 0.2 | 401 | 0.2 |
| Барилга | 14 687 | 7.7 | 15 858 | 7.7 | 17 522 | 7.6 | 18 616 | 7.5 |
| Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ | 76 697 | 40.4 | 81 327 | 39.4 | 88 256 | 38.3 | 94 948 | 38.2 |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 4 121 | 2.2 | 4 697 | 2.3 | 6 045 | 2.6 | 6 973 | 2.8 |
| Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа | 4 730 | 2.5 | 5 211 | 2.5 | 5 753 | 2.5 | 6 335 | 2.5 |
| Мэдээлэл, холбоо | 4 973 | 2.6 | 5 607 | 2.7 | 6 591 | 2.9 | 7 215 | 2.9 |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 4 682 | 2.5 | 4 848 | 2.4 | 5 056 | 2.2 | 5 193 | 2.1 |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 2 089 | 1.1 | 2 203 | 1.1 | 2 263 | 1.0 | 2 336 | 0.9 |
| Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 10 612 | 5.6 | 11 659 | 5.7 | 12 810 | 5.6 | 14 079 | 5.7 |
| Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 9 636 | 5.1 | 10 641 | 5.2 | 12 838 | 5.6 | 14 306 | 5.7 |
| Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал | 1 561 | 0.8 | 1 605 | 0.8 | 1 669 | 0.7 | 1 714 | 0.7 |
| Боловсрол | 6 984 | 3.7 | 7 186 | 3.5 | 7 401 | 3.2 | 7 549 | 3.0 |
| Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа | 3 714 | 2.0 | 3 770 | 1.8 | 3 826 | 1.7 | 3 962 | 1.6 |
| Урлаг, үзвэр, тоглоом наадам | 2 101 | 1.1 | 2 278 | 1.1 | 2 475 | 1.1 | 2 610 | 1.0 |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 18 737 | 9.9 | 22 902 | 11.1 | 29 537 | 12.8 | 31 817 | 12.8 |
| Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | 36 | 0.0 | 36 | 0.0 | 37 | 0.0 | 37 | 0.0 |



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.**ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

Энэ бүлэгт хуулийн этгээд, түүнд ажиллагчдын тоо, тэдгээрийн борлуулалтын орлогын хэмжээг авч үзлээ. Хуулийн этгээдийн ажиллагчдын тоо, борлуулалтын орлого нь тухайн нэгжийн үйл ажиллагааны цар хүрээг илэрхийлэх гол үзүүлэлт бөгөөд статистикийн түүвэр судалгаанд хамрагдах нэгжийг тодорхойлох үндсэн үзүүлэлт болдог.

4.1 ХУУЛИЙН ЭТГЭЭД, ажиллагчдын тооны бүлгээр


2022 онд үйл ажиллагаа явуулсан хуулийн этгээдийн 77.4 мянга буюу 84.3 хувь нь 1-9 ажиллагчидтай байгаа бол 2.7 мянга буюу 3.0 хувь нь 50 ба түүнээс дээш ажиллагчидтай байна.

ХҮСНЭГТ 4.1. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД, ажиллагчдын тооны бүлгээр, жил бүрийн эцэст

| Ажиллагчдын тооны бүлэг | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|-------------------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|
| БҮГД | 71 716 | 75 522 | 76 329 | 81 533 | 91 811 |
| 1-9 | 59 121 | 62 409 | 63 089 | 67 804 | 77 413 |
| 10-19 | 5 922 | 6 227 | 6 107 | 6 350 | 6 823 |
| 20-49 | 4 462 | 4 632 | 4 694 | 4 815 | 4 868 |
| 50 ба түүнээс дээш | 2 211 | 2 254 | 2 439 | 2 564 | 2 707 |

Үйл ажиллагаа явуулсан 1-9 ажиллагчидтай хуулийн этгээдийн тоо 2022 онд 2018 оноос 30.9 хувиар, 10-19 ажиллагчидтай хуулийн этгээдийн тоо 15.2 хувиар, 20-49 ажиллагчидтай хуулийн этгээдийн тоо 9.1 хувиар, 50 ба түүнээс дээш ажиллагчидтай хуулийн этгээдийн тоо 22.4 хувиар тус тус өсжээ. Харин 2021 оноос 1-9 ажиллагчидтай хуулийн этгээдийн тоо 14.2 хувиар, 10-19 ажиллагчидтай хуулийн этгээдийн тоо 7.4 хувиар, 20-49 ажиллагчидтай хуулийн этгээдийн тоо 1.1 хувиар, 50 ба түүнээс дээш ажиллагчидтай хуулийн этгээдийн тоо 5.6 хувиар тус тус өссөн байна.

ЗУРАГ 4.1 ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТОО, ажиллагчдын тооны бүлгээр, 2022 он



Баруун бүсэд 2022 онд үйл ажиллагаа эрхэлсэн 6.3 мянган хуулийн этгээдийн 81.2 хувь нь 1-9 ажиллагчидтай, 7.9 хувь нь 10-19 ажиллагчидтай нэгж, 7.8 хувь нь 20-49 ажиллагчидтай нэгж, 3.1 хувь нь 50 ба түүнээс дээш ажиллагчидтай байна.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлсэн 65.2 мянган хуулийн этгээдийн 85.7 хувь нь 1-9 ажиллагчидтай, 7.2 хувь нь 10-19 ажиллагчидтай, 4.2 хувь нь 20-49 ажиллагчидтай, 2.8 хувь нь 50 ба түүнээс дээш ажиллагчидтай байна.

ХҮСНЭГТ 4.2.ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД, бүс, ажиллагчдын тооны бүлгээр, 2022 он

| Бүс | БҮГД | Ажиллагчдын тооны бүлгээр | | | | | | | |
|-------------|---------------|---------------------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------------|--------------|
| | | 1-9 | | 10-19 | | 20-49 | | 50 ба түүнээс дээш | |
| | | БҮГД | % | БҮГД | % | БҮГД | % | БҮГД | % |
| Бүгд | 91 811 | 77 413 | 100.0 | 6 823 | 100.0 | 4 868 | 100.0 | 2 707 | 100.0 |
| Баруун | 6 311 | 5 122 | 6.6 | 499 | 7.3 | 495 | 10.2 | 195 | 7.2 |
| Хангайн | 7 854 | 6 343 | 8.2 | 621 | 9.1 | 627 | 12.9 | 263 | 9.7 |
| Төвийн | 9 143 | 7 362 | 9.5 | 779 | 11.4 | 677 | 13.9 | 325 | 12.0 |
| Зүүн | 3 283 | 2 672 | 3.5 | 217 | 3.2 | 299 | 6.1 | 95 | 3.5 |
| Улаанбаатар | 65 220 | 55 914 | 72.2 | 4 707 | 69.0 | 2 770 | 56.9 | 1 829 | 67.6 |

Үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 37.4 мянган ААН-ийн 78.3 хувь нь 1-9 ажиллагчидтай, 8.6 хувь нь 10-19 ажиллагчидтай, 8.3 хувь нь 20-49 ажиллагчидтай, 4.8 хувь нь 50-иас дээш ажиллагчидтай байна.

ХҮСНЭГТ 4.3. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД, үйл ажиллагааны чиглэл, ажиллагчдын тооны бүлгээр, 2022 он

| Салбар | БҮГД | Ажиллагчдын тооны бүлгээр | | | |
|---------------|---------------|---------------------------|--------------|--------------|--------------------|
| | | 1-9 | 10-19 | 20-49 | 50 ба түүнээс дээш |
| БҮГД | 91 811 | 77 413 | 6 823 | 4 868 | 2 707 |
| Хөдөө аж ахуй | 3 199 | 2 919 | 225 | 45 | 10 |
| Аж үйлдвэр | 7 972 | 6 231 | 829 | 503 | 409 |
| Барилга | 7 684 | 6 063 | 960 | 515 | 146 |
| Худалдаа | 35 563 | 32 939 | 1 588 | 688 | 348 |
| Үйлчилгээ | 37 393 | 29 261 | 3 221 | 3 117 | 1 794 |

Үйл ажиллагаа явуулсан хуулийн этгээдийг хариуцлагын хэлбэрийн хувьд ажиллагчдын тооны бүлгүүдэд хэрхэн хуваарилагдаж байгааг авч үзэхэд, компани (88.1 хувь), нөхөрлөл (92.6 хувь), хоршоо (83.1 хувь), төрийн бус байгууллага (89.7 хувь)-ын 80-аас дээш хувь нь 1-9 ажиллагчидтай байхад ТӨҮГ, ОНӨҮГ, төсвийн байгууллага нь ажиллагчдын тооны бүлгүүдэд харьцангуй жигд тархалттай байна.


ХҮСНЭГТ 4.4. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД, хариуцлагын хэлбэр, ажиллагчдын тооны бүлгээр, 2022 он

| Хариуцлагын хэлбэр | БҮГД | Ажиллагчдын тооны бүлгээр | | | | | | | |
|---------------------|---------------|---------------------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------------|--------------|
| | | 1-9 | | 10-19 | | 20-49 | | 50 ба түүнээс дээш | |
| | | БҮГД | % | БҮГД | % | БҮГД | % | БҮГД | % |
| БҮГД | 91 811 | 77 413 | 100.0 | 6 823 | 100.0 | 4 868 | 100.0 | 2 707 | 100.0 |
| Компани | 76 230 | 67 175 | 86.8 | 5 117 | 75.0 | 2 540 | 52.2 | 1 398 | 51.6 |
| Хоршоо | 1 570 | 1 305 | 1.7 | 182 | 2.7 | 81 | 1.7 | 2 | 0.1 |
| Нөхөрлөл | 1 584 | 1 467 | 1.9 | 84 | 1.2 | 30 | 0.6 | 3 | 0.1 |
| ТӨҮГ, ОНӨҮГ | 452 | 198 | 0.3 | 98 | 1.4 | 76 | 1.6 | 80 | 3.0 |
| Төсвийн байгууллага | 4 896 | 1 103 | 1.4 | 772 | 11.3 | 1 912 | 39.3 | 1 109 | 41.0 |
| ТББ | 6 380 | 5 725 | 7.4 | 419 | 6.1 | 168 | 3.5 | 68 | 2.5 |
| Бусад | 699 | 440 | 0.6 | 151 | 2.2 | 61 | 1.3 | 47 | 1.7 |

Үйл ажиллагаа явуулсан хуулийн этгээдийн ажиллагчдын тооны бүтцийг өмчийн хэлбэрээр авч үзэхэд, 1-9 ажиллагчидтай хуулийн этгээдийн дийлэнх нь буюу 95.5 хувь нь Монгол Улсын иргэний хувийн өмчийнх байна. Харин 10-19 ажиллагчидтай хуулийн этгээдийн 82.2 хувь нь Монгол Улсын иргэний хувийн өмчийн хуулийн этгээд, 12.9 хувь нь төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгаа бол


20-49 ажиллагчидтай хуулийн этгээдийн 54.6 хувь нь Монгол Улсын иргэний хувийн өмчийнх, 41.2 хувь нь төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд байна.

ЗУРАГ 4.2. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД, өмчийн хэлбэр, ажиллагчдын тооны бүлгээр, 2022 он



Нийт хуулийн этгээдийн 91.8 мянга (36.9%) нь үйл ажиллагаа явуулсан ба эдгээр хуулийн этгээдэд нийт 866.0 мянган хүн ажиллаж байна. Үйл ажиллагаа 2022 онд явуулсан хуулийн этгээдийн ажиллагчдын тоог өмнөх онтой харьцуулахад 55.6 мянга (6.4%)-аар нэмэгдсэн байна.

ЗУРАГ 4.3. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТҮҮНД АЖИЛЛАГЧИД, мянган хүнээр, жил бүрийн эцэст



Үйл ажиллагаа 2022 онд явуулсан хуулийн этгээдийн ажиллагчдын тоог бүсээр авч


үзэхэд, Улаанбаатар хотод нийт ажиллагчдын 70.6 хувь нь, Төвийн бүсэд 10.6 хувь нь, Хангайн бүсэд 9.1 хувь нь, Баруун бүсэд 6.3 хувь нь, Зүүн бүсэд 3.4 хувь нь байна.

ХҮСНЭГТ 4.5. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТҮҮНД АЖИЛЛАГЧИД, бүсээр, жил бүрийн эцэст

| Бүс | 2020 | | 2021 | | 2022 | |
|-------------|----------------|--------------------------|----------------|--------------------------|----------------|--------------------------|
| | Хуулийн этгээд | Ажиллагчдын тоо, мян.хүн | Хуулийн этгээд | Ажиллагчдын тоо, мян.хүн | Хуулийн этгээд | Ажиллагчдын тоо, мян.хүн |
| БҮГД | 76 329 | 773.0 | 81 533 | 810.4 | 91 811 | 866.0 |
| Баруун | 6 231 | 55.2 | 6 042 | 54.1 | 6 311 | 54.3 |
| Хангайн | 7 328 | 77.2 | 7 158 | 77.4 | 7 854 | 79.1 |
| Төвийн | 8 305 | 87.1 | 8 325 | 89.5 | 9 143 | 91.4 |
| Зүүн | 2 874 | 28.9 | 2 951 | 28.6 | 3 283 | 29.8 |
| Улаанбаатар | 51 591 | 524.5 | 57 057 | 560.8 | 65 220 | 611.6 |


Хуулийн этгээдийн ажиллагчдын тоогоор Улаанбаатар хот (611.6 мянган хүн), Орхон (25.2 мянган хүн), Өмнөговь (25.0 мянган хүн), Дархан-Уул (19.9 мянган хүн), Сэлэнгэ (16.2 мянган хүн) аймгууд хамгийн их, харин Говьсүмбэр (3.4 мянган хүн), Дундговь (5.2 мянган хүн), Сүхбаатар (7.1 мянган хүн), Говь-Алтай (8.4 мянган хүн) аймгууд хуулийн этгээдийн ажиллагчдын тоогоор хамгийн бага байна.

ЗУРАГ 4.4. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТҮҮНД АЖИЛЛАГЧИД, ажиллагчдын тооны бүлэг, аймаг, нийслэлээр, 2022 он



Ажиллагчдын тооны бүлгээр харуулсан үйл ажиллагаа явуулсан хуулийн этгээдийн тоо болон ажиллагчдын тоо нь хоорондоо урвуу хамааралтай байна.

ЗУРАГ 4.5. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТҮҮНД АЖИЛЛАГЧИД, ажиллагчдын тооны бүлгээр, 2022 он



Хуулийн этгээдийн ажиллагчдын 562.8 мянга (65.0%) нь компанид, 215.2 мянга (24.9%) нь төсвийн байгууллагад, 34.8 мянга (4.0%) нь төрийн бус байгууллагад, 53.2 мянга (6.1%) нь бусад хэлбэрийн хуулийн этгээдэд ажиллаж байна.

ХҮСНЭГТ 4.6. ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТҮҮНД АЖИЛЛАГЧИД, хариуцлагын хэлбэрээр, жил бүрийн эцэст

| Хариуцлагын хэлбэр | 2020 | | 2021 | | 2022 | |
|---------------------|----------------|--------------------------|----------------|--------------------------|----------------|--------------------------|
| | Хуулийн этгээд | Ажиллагчдын тоо, мян.хүн | Хуулийн этгээд | Ажиллагчдын тоо, мян.хүн | Хуулийн этгээд | Ажиллагчдын тоо, мян.хүн |
| БҮГД | 76 329 | 773.0 | 81 533 | 810.4 | 91 811 | 866.0 |
| Компани | 59 954 | 488.2 | 63 492 | 509.7 | 76 230 | 562.8 |
| Хоршоо | 1 700 | 7.2 | 1 402 | 6.1 | 1 584 | 7.0 |
| Нөхөрлөл | 1 532 | 7.8 | 1 431 | 7.3 | 1 570 | 8.4 |
| ТӨҮГ, ОНӨҮГ | 343 | 27.1 | 395 | 26.6 | 452 | 27.5 |
| Төсвийн байгууллага | 4 674 | 199.2 | 4 791 | 207.2 | 4 896 | 215.2 |
| ТББ | 7 755 | 37.9 | 9 552 | 46.2 | 6 380 | 34.8 |
| Бусад | 371 | 5.6 | 470 | 7.2 | 699 | 10.3 |


Ажиллагчдын тоог өмчийн хэлбэрээр авч үзэхэд, Монгол Улсын иргэний хувийн хуулийн этгээдийн ажиллагчдын тоо өмнөх оны дүнгээс 8.9 хувиар, төрийн болон орон нутгийн өмчийн болон хувийн гадаадтай хамтарсан өмчлөлтэй хуулийн этгээдийн ажиллагчдын тоо тус тус 3.5 хувиар, гадаад улсын хуулийн этгээдийн ажиллагчдын тоо 5.9 хувиар тус тус нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 4.7. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТҮҮНД АЖИЛЛАГЧИД, өмчийн хэлбэрээр, жил бүрийн эцэст

| Өмчийн хэлбэр | 2020 | | 2021 | | 2022 | |
|--|----------------|--------------------------|----------------|--------------------------|----------------|--------------------------|
| | Хуулийн этгээд | Ажиллагчдын тоо, мян.хүн | Хуулийн этгээд | Ажиллагчдын тоо, мян.хүн | Хуулийн этгээд | Ажиллагчдын тоо, мян.хүн |
| БҮГД | 76 329 | 773.0 | 81 533 | 810.4 | 91 811 | 866.0 |
| Төрийн болон орон нутгийн өмчийн | 5 105 | 262.5 | 5 277 | 271.5 | 5 443 | 281.1 |
| Монгол Улсын иргэний хувийн Хувийн гадаадтай хамтарсан | 68 409 | 457.1 | 73 575 | 486.1 | 83 466 | 529.5 |
| Гадаад улсын | 586 | 21.5 | 553 | 20.9 | 612 | 21.6 |
| | 2 229 | 31.9 | 2 128 | 31.9 | 2 290 | 33.8 |

2022 онд үйл ажиллагаа явуулсан хуулийн этгээдийн 475.4 мянга (54.9%) нь үйлчилгээ, 170.0 мянга (19.6%) нь худалдаа, 144.9 мянга (16.7%) нь аж үйлдвэр, 62.6 мянга (7.2%) нь барилга, 13.1 мянга (1.5%) нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байна.

ЗУРАГ 4.6. АЖИЛЛАГЧДЫН ТОО, үйл ажиллагааны чиглэлээр, мянган хүн, 2022 он



4.2 АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГО

ҮСХ нь аж ахуйн нэгжийн орлогын хэмжээг Татварын Ерөнхий Газрын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын улирлын тайлангийн мэдээлэлд үндэслэн бүртгэдэг.

БРӨС-д 2022 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 79.8 мянган аж ахуйн нэгж (компани, нөхөрлөл, хоршоо, ТӨҮГ, ОНӨҮГ) 130.4 их наяд төгрөгийн орлого олсон байна.

Аж ахуйн нэгжийн орлогын хэмжээг бүсээр авч үзвэл, Улаанбаатар хотод 110.8 их наяд төгрөг (85.0%), Төвийн бүсэд 9.4 их наяд төгрөг (7.2%), Хангайн бүсэд 6.6 их наяд төгрөг (5.1%), Зүүн бүсэд 1.7 их наяд төгрөг (1.3%), Баруун бүсэд 1.8 их наяд төгрөг (1.4%) ногдож байна.


ХҮСНЭГТ 4.8. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГО, бүс, тэрбум төгрөгөөр, жил бүрийн эцэст

| Бүс | 2020 | | 2021 | | 2022 | |
|-------------|-----------------|--------------|-----------------|--------------|------------------|--------------|
| | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % |
| БҮГД | 80 204.5 | 100.0 | 96 454.1 | 100.0 | 130 405.4 | 100.0 |
| Баруун | 982.8 | 1.2 | 1 178.4 | 1.2 | 1 811.0 | 1.4 |
| Хангайн | 4 124.6 | 5.1 | 5 792.7 | 6.0 | 6 603.8 | 5.1 |
| Төвийн | 5 480.6 | 6.8 | 5 922.6 | 6.1 | 9 453.1 | 7.2 |
| Зүүн | 1 023.1 | 1.3 | 1 724.0 | 1.8 | 1 690.2 | 1.3 |
| Улаанбаатар | 68 593.3 | 85.5 | 81 836.4 | 84.8 | 110 847.3 | 85.0 |

Аж ахуйн нэгжийн орлогыг 2021 оны орлоготой харьцуулахад 34.0 их наяд төгрөг (35.2%)-өөр өссөн байна.


Аж ахуйн нэгжийн орлогыг аймаг, нийслэлээр авч үзвэл, Улаанбаатар хот 110.8 их наяд төгрөг, Өмнөговь аймаг 5.9 их наяд төгрөг, Орхон аймаг 5.2 их наяд төгрөгийн орлогоор хамгийн өндөр орлоготой байгаа бол Булган аймаг 145.1 тэрбум, Дундговь аймаг 144.1 тэрбум төгрөгийн орлоготой байгаа нь хамгийн бага байна.

ЗУРАГ 4.7. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГО, аймаг, нийслэл, тэрбум төгрөгөөр, 2022 он



Орлогын бүлгээр авч үзвэл, 2022 онд 2.5 тэрбум төгрөгнөөс дээш орлоготой аж ахуйн нэгжийн тоо 4.7 мянга болж, орлого нь 112.9 их наяд төгрөгт хүрсэн байна.


ЗУРАГ 4.8. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО БОЛОН ОРЛОГО, орлогын бүлэг, тэрбум төгрөгөөр, 2022 он



Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн орлогыг үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл, 2022 онд худалдааны салбар 51.4 их наяд төгрөг (39.4 хувь)-ийн орлоготой байгаа нь хамгийн өндөр хувийг эзэлж байна. Харин ХАА-н салбар 870.6 тэрбум төгрөг буюу 0.7 хувийг эзэлж байгаа нь хамгийн бага байна.


Өмнөх онтой харьцуулахад үйлчилгээний салбарын орлогын хувийн жин 1.6 нэгж хувиар, худалдааны салбар 1.3 нэгж хувиар, хөдөө аж ахуйн салбар 0.1 нэгж хувиар тус тус нэмэгдсэн бол аж үйлдвэрийн салбар 2.4 нэгж хувиар, барилгын салбар 0.5 нэгж хувиар тус тус буурсан байна.

ЗУРАГ 4.9. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, үйл ажиллагааны чиглэлээр, жил бүрийн эцэст



Үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжийн орлогыг хариуцлагын хэлбэрээр нь авч үзвэл, 114.4 их наяд төгрөг буюу 87.7 хувийг ХХК, 10.4 их наяд төгрөг буюу 8.0 хувийг ХК эзэлж, үлдсэн 5.5 их наяд төгрөгийн 4.2 хувийг ТӨҮГ, ОНӨҮГ, нөхөрлөл, хоршоо бүрдүүлж байна.


ЗУРАГ 4.10. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГО, хариуцлагын хэлбэр, тэрбум төгрөгөөр, 2022 он



Аж ахуйн нэгжийн 2022 оны орлогын 116.4 их наяд төгрөг буюу 89.3 хувийг хувийн секторын нэгжүүд, 14.0 их наяд төгрөг буюу 10.7 хувийг төрийн болон орон нутгийн өмчийн нэгжүүд бүрдүүлж байна.

ХҮСНЭГТ 4.9. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, өмчийн хэлбэр, тэрбум төгрөгөөр, жил бүрийн эцэст

| Өмчийн хэлбэр | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|----------------------------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|------------------|
| БҮГД | 71 127.0 | 76 874.9 | 80 204.5 | 96 454.1 | 130 405.4 |
| Төрийн болон орон нутгийн өмчийн | 9 422.2 | 10 264.8 | 9 429.0 | 10 411.6 | 13993.9 |
| Монгол Улсын иргэний хувийн | 44 398.8 | 48 932.0 | 53 741.4 | 65 240.8 | 92794.5 |
| Хувийн гадаадтай хамтарсан | 8 082.2 | 7 637.8 | 7 983.1 | 10 670.3 | 10657.7 |
| Гадаад улсын | 9 223.8 | 10 040.3 | 9 051.0 | 10 131.3 | 12959.3 |



ТАВДУГААР БҮЛЭГ.

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИД

ТАВДУГААР БҮЛЭГ.**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИД**

Монгол Улсын эдийн засгийн хөгжилд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн оруулж буй хувь нэмрийг харуулах, “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр”, “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-г үнэлэх зорилгоор энэхүү бүлэгт жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн мэдээллийг танилцуулж байна.

ҮСХ нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн тоо мэдээллийг Монгол Улсын “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай” хуулийн 4.1.1, 5.1¹, 7.1-р заалтуудыг үндэслэн статистикийн бизнес регистрийн сангаас тодорхойлж гаргасан.

Монгол Улсын “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай” хуулийн 4.1.1 дүгээр заалт: “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” гэж 200 хүртэл ажилтантай, жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг ойлгоно.

Монгол Улсын “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай” хуулийн 7.1 дүгээр заалт:

7.1. Дараах үйл ажиллагааг эрхэлдэг аж ахуйн нэгж энэ хуульд заасан жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид хамаарахгүй. Үүнд:

7.1.2. Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ;

7.1.3. Зуучлалын үйлчилгээ;

7.1.4. Хууль зүйн зөвлөх үйлчилгээ;

7.1.5. Худалдаа, үйлчилгээний сүлжээ;

7.1.6. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13.4, 13.5-д заасан үйл ажиллагаа;

7.1.7. Ашигт малтмал хайх, газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах, боловсруулах.

7.1.8. тамхи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, экспорт;

¹ 5.1.1. “бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” гэж 10 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг;

5.1.2. “жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” гэж 10-50 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг;


5.1.3. “дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” гэж 50-200 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 1.0--2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг.

7.1.9.төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалаа;

7.1.10.банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаа, даатгалын үйлчилгээ.

БРӨС-д 2022 оны жилийн эцсийн байдлаар 91.8 мянган хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байгаагийн 69.5 мянга (75.7%) нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байна. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн тоо өмнөх 2021 оноос 19.9 хувь, 2018 оноос 35.0 хувиар тус тус нэмэгдсэн байна.

ЗУРАГ 5.1. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО, жил бүрийн эцэст



Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийн тоог бүсээр авч үзвэл, Улаанбаатарт 50.2 мянга (72.2%) нь, Төвийн бүсэд 6.6 мянга (9.5%) нь, Хангайн бүсэд 5.7 мянга (8.1%) нь, Баруун бүсэд 4.8 мянга (6.9%) нь, Зүүн бүсэд 2.3 (3.3%) мянга нь үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ 5.1. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО, бүсээр, жил бүрийн эцэст

| Бүс | 2018 | | 2019 | | 2020 | | 2021 | | 2022 | |
|-------------|---------------|------------|---------------|------------|---------------|------------|---------------|------------|---------------|------------|
| | Тоо | % | Тоо | % | Тоо | % | Тоо | % | Тоо | % |
| БҮГД | 51 504 | 100 | 53 810 | 100 | 55 230 | 100 | 58 015 | 100 | 69 539 | 100 |
| Баруун | 4 814 | 9.3 | 4 677 | 8.7 | 4 496 | 8.1 | 4 192 | 7.2 | 4 779 | 6.9 |

СТАТИСТИКИЙН БИЗНЕС РЕГИСТРИЙН ТАНИЛЦУУЛГА – 2022

| | | | | | | | | | | |
|-------------|--------|------|--------|------|--------|------|--------|------|--------|------|
| Хангайн | 5 288 | 10.3 | 5 271 | 9.8 | 5 014 | 9.1 | 5 012 | 8.6 | 5 651 | 8.1 |
| Төвийн | 6 055 | 11.8 | 6 013 | 11.2 | 5 782 | 10.5 | 5 690 | 9.8 | 6 589 | 9.5 |
| Зүүн | 1 887 | 3.7 | 1 991 | 3.7 | 1 943 | 3.5 | 1 972 | 3.4 | 2 282 | 3.3 |
| Улаанбаатар | 33 460 | 65.0 | 35 858 | 66.6 | 37 995 | 68.8 | 41 149 | 70.9 | 50 238 | 72.2 |

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл, худалдааны салбарт 46.7 хувь, үйлчилгээний салбарт 30.6 хувь, барилгын салбарт 9.9 хувь, аж үйлдвэрийн салбарт 8.4 хувь, хөдөө аж ахуйн салбарт 4.4 хувь нь үйл ажиллагаа явуулж байна.


ХҮСНЭГТ 5.2. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, жил бүрийн эцэст

| Бүс | 2018 | | 2019 | | 2020 | | 2021 | | 2022 | |
|---------------|---------------|------------|---------------|------------|---------------|------------|---------------|------------|---------------|------------|
| | Тоо | % | Тоо | % | Тоо | % | Тоо | % | Тоо | % |
| БҮГД | 51 504 | 100 | 53 810 | 100 | 55 230 | 100 | 58 015 | 100 | 69 539 | 100 |
| Хөдөө аж ахуй | 2 785 | 5.4 | 2 704 | 5.0 | 2 665 | 4.8 | 2 558 | 4.4 | 3 030 | 4.4 |
| Аж үйлдвэр | 4 706 | 9.1 | 4 711 | 8.8 | 4 779 | 8.7 | 4 944 | 8.5 | 5 850 | 8.4 |
| Барилга | 5 250 | 10.2 | 5 469 | 10.2 | 5 616 | 10.2 | 5 999 | 10.3 | 6 857 | 9.9 |
| Худалдаа | 23 813 | 46.2 | 25 112 | 46.7 | 25 811 | 46.7 | 27 136 | 46.8 | 32 493 | 46.7 |
| Үйлчилгээ | 14 950 | 29.0 | 15 814 | 29.4 | 16 359 | 29.6 | 17 378 | 30.0 | 21 309 | 30.6 |

2022 оны байдлаар жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 69.5 мянган аж ахуйн нэгжийн 75.4 хувь нь бичил, 2.5 хувь нь жижиг, 0.1 хувь нь дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байна.


ХҮСНЭГТ 5.3. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, жил бүрийн эцэст

| Ажиллагчдын тооны бүлэг | 2021 | | | | 2022 | | | |
|-------------------------|---------------|------------------|----------------------|----------------|---------------|------------------|----------------------|----------------|
| | Нийт | 300.0 сая хүртэл | 300.0 сая-1.0 тэрбум | 1.0-2.5 тэрбум | Нийт | 300.0 сая хүртэл | 300.0 сая-1.0 тэрбум | 1.0-2.5 тэрбум |
| Нийт | 58 015 | 46 299 | 8 056 | 3 660 | 69 539 | 54 724 | 10 131 | 4 684 |
| 1-10 | 52 397 | 43 911 | 6 323 | 2 163 | 63 854 | 52 455 | 8 357 | 3 042 |
| 10-50 | 5 403 | 2 322 | 1 700 | 1 381 | 5 508 | 2 203 | 1 750 | 1 555 |




Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхэлдэг нэгжийн тоогоор Улаанбаатар (50.2 мянга), Орхон (1.8 мянга), Дархан-Уул (1.6 мянга), Өмнөговь (1.5 мянга), Сэлэнгэ (1.4 мянга), Ховд (1.3 мянга) аймгууд улсдаа тэргүүлж байна. Говь-Алтай (582), Сүхбаатар (522), Дундговь (410), Говьсүмбэр (179) аймгуудад жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхэлдэг нэгжийн тоо бага байна.

ЗУРАГ 5.2. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛДЭГ НЭГЖИЙН ТОО, аймаг, нийслэлээр, 2022 он




Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч нэгжийн ажиллагчдын тоо 2022 онд 256.0 мянган хүн байгаа нь 2021 оноос 20.3 мянга (8.6 %) -аар өссөн үзүүлэлттэй байна. Харин 2018 онтой харьцуулахад 50.3 мянга (24.4 %) -аар нэмэгдсэн байна.

ЗУРАГ 5.3. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖИД АЖИЛЛАГЧДЫН ТОО, мян.хүн, жил бүрийн эцэст




Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжид ажиллагчдын тоог нэгжийн борлуулалтын орлогын бүлгээр харуулахад, 300 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой 54.7 мянган аж ахуйн нэгжид 149.6 мянга (58.4 %), 300.1 сая төгрөгөөс 1.0 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой 10.1 мянган аж ахуйн нэгжид 57.5 мянга (22.5 %) нь, 1.0-2.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой 4.7 мянган аж ахуйн нэгжид 48.9 мянган (19.1 %) хүн ажиллаж байна.

ЗУРАГ 5.4. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ НЭГЖ, ТҮҮНД АЖИЛЛАГЧДЫН ТОО, борлуулалтын орлогын бүлгээр, 2022 он




Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч 69.5 мянган аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого 2022 онд 16.1 их наяд төгрөг байна.

ЗУРАГ 5.5. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ НЭГЖ БОЛОН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, тэрбум төгрөгөөр, 2022 он



ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ХОРШООНЫ ҮЗҮҮЛЭЛТ



ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ХОРШООНЫ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

6.1. ХОРШООНЫ ТОО, ТӨРӨЛ, БАЙРШИЛ

Хоршоо нь эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, ардчилсан хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээдийг хэлнэ (Иргэний хууль, 36.4 дэх заалт).


Монгол Улсын Засгийн газар, хоршоо, хоршоог дэмжигч байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, хоршоо хөгжих эрх зүй, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх замаар дэмжлэг үзүүлэх багагүй төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа бөгөөд тэдгээрийн эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг харуулах зорилгоор энэхүү бүлэгт хоршоодын тоо, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хоршооны гишүүдийн тоо зэрэг мэдээллийг танилцуулж байна.

БРӨС-д бүртгэлтэй хоршоо 2022 онд 5.1 мянга болж, өмнөх оноос 404 (8.6%)-өөр, 2020 оноос 548 (12.1%)-аар, 2019 оноос 476 (10.3%)-аар, 2018 оноос 564 (12.5%)-өөр тус тус нэмэгдсэн байна.

БРӨС-д 2022 онд бүртгэлтэй 5.1 мянган хоршооны 4.8 мянга (95.0%) нь анхан шатны хоршоо, 253 (5.0%) нь дундын хоршоо байна.

Нийт хоршооны 1.6 мянга (31.2%) нь үйл ажиллагаа явуулсан бол 3.5 мянга (72.4%) нь үйл ажиллагаа явуулаагүй байна.

ЗУРАГ 6.1. ХОРШОО, хоршооны төрлөөр, жил бүрийн эцэст




Нийт хоршооны 1.5 мянга (29.6%) нь Баруун бүсэд, 1.3 мянга (26.5%) нь Хангайн бүсэд, 996 (19.6%) нь Төвийн бүсэд, 885 (17.4%) нь Улаанбаатар хотод, 352 (6.9%) нь Зүүн бүсэд байршилтай байна.

ХҮСНЭГТ 6.1. ХОРШОО, хоршооны төрөл, бүсээр, 2022 он

| Бүс | БҮГД | | Хоршооны төрөл | | | |
|-------------|--------------|--------------|----------------|--------------|------------|--------------|
| | | | Анхан шатны | | Дундын | |
| | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % |
| БҮГД | 5 081 | 100.0 | 4 828 | 100.0 | 253 | 100.0 |
| Баруун | 1 502 | 29.6 | 1 451 | 30.1 | 51 | 20.2 |
| Хангайн | 1 346 | 26.5 | 1 295 | 26.8 | 51 | 20.2 |
| Төвийн | 996 | 19.6 | 959 | 19.9 | 37 | 14.6 |
| Зүүн | 352 | 6.9 | 329 | 6.8 | 23 | 9.1 |
| Улаанбаатар | 885 | 17.4 | 794 | 16.4 | 91 | 36.0 |

Хоршооны тоогоор Улаанбаатар хот (885), Завхан (432), Баян-Өлгий (352), Хөвсгөл (322), Төв (329) аймгууд өндөр байгаа бол Сүхбаатар (86), Орхон (77), Дорноговь (70), Говьсүмбэр (37) аймгууд хамгийн цөөн хоршоотой байна.

ЗУРАГ 6.2. ХОРШОО, аймаг, нийслэлээр, 2022 он



6.2. ХОРШООНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

2022 онд БРӨС-д бүртгэлтэй 5.1 мянган хоршоо нь 244.3 мянган гишүүд, 57.3 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.

Хоршоо нь өмчийн бусад хэлбэрийн хуулийн этгээдээс ялгарах зарим онцлогтой байдаг. Үүнд:

- Хоршооны зорилго нь гишүүдийнхээ нийтлэг хэрэгцээг хангахад чиглэсэн байна (Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулга, 27.1 дэх заалт).
- Саналын эрхийн хувьд хоршооны гишүүд оруулсан хөрөнгөөс үл хамааран саналын тэгш эрх эдэлдэг (Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулга, 17.1.1 дэх заалт).
- Хоршооны хөрөнгө нь гишүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгөөс бүрдэх ба дундын өмч гэж үздэг (Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулга, 22.1.1 дэх заалт).

Хоршооны гишүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2021 оны дүнгээс 8.6 тэрбум төгрөг (17.7%)-өөр, гишүүдийн тоо 9.0 мянга (3.8%)-аар тус тус нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 6.2. ХОРШООНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, бүсээр, жил бүрийн эцэст

| Бүс | 2021 | | | | 2022 | | | |
|-------------|---|--------------|----------------|--------------|---|--------------|----------------|--------------|
| | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, сая төг | | Гишүүд | | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, сая төг | | Гишүүд | |
| | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % |
| БҮГД | 48 718.4 | 100.0 | 235 355 | 100.0 | 57 329.7 | 100.0 | 244 336 | 100.0 |
| Баруун | 12 725.1 | 26.1 | 63 211 | 26.9 | 13 590.9 | 23.7 | 67 267 | 27.5 |
| Хангайн | 9 601.4 | 19.7 | 67 547 | 28.7 | 10 442.7 | 18.2 | 69 174 | 28.3 |
| Төвийн | 5 363.6 | 11.0 | 34 674 | 14.7 | 5 824.9 | 10.2 | 37 702 | 15.4 |
| Зүүн | 2 755.1 | 5.7 | 14 892 | 6.3 | 2 778.4 | 4.8 | 15 537 | 6.4 |
| Улаанбаатар | 18 273.1 | 37.5 | 55 031 | 23.4 | 24 692.8 | 43.1 | 54 656 | 22.4 |

Хоршооны хувь нийлүүлсэн хөрөнгийн 24.7 тэрбум төгрөг (43.1%) нь Улаанбаатар хотын, 13.6 тэрбум төгрөг (23.7%) нь Баруун бүсийн, 10.4 тэрбум төгрөг (18.2%) нь Хангайн бүсийн, 5.8 тэрбум төгрөг (10.2%) нь Төвийн бүсийн, 2.8 тэрбум төгрөг (4.8%) нь Зүүн бүсийн хоршоодод ногдож байна.

ХҮСНЭГТ 6.3. ХОРШООНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, үйл ажиллагааны чиглэлээр, 2022 он

| Хоршооны үзүүлэлтүүд | БҮГД | Үйл ажиллагааны чиглэл | | | | |
|---|-----------------|------------------------|------------|----------|-----------------|---------|
| | | ХАА | Аж үйлдвэр | Худалдаа | Санхүү, даатгал | Бусад |
| БҮГД | 5 081 | 1 579 | 813 | 1 514 | 609 | 566 |
| Анхан шатны | 4 828 | 1 537 | 776 | 1 430 | 528 | 557 |
| Дундын | 253 | 42 | 37 | 84 | 81 | 9 |
| Үндсэн үзүүлэлт | | | | | | |
| Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, сая төг | 57 329.7 | 8 024.0 | 4 180.1 | 11 403.6 | 30 351.0 | 3 371.0 |
| Гишүүдийн тоо | 244 336 | 33 661 | 17 543 | 96 022 | 86 441 | 10 669 |

Дундын хоршооны 84 (33.2%) нь үйлчилгээний салбарт, анхан шатны хоршооны 1.5 мянга (31.8%) нь ХАА-н салбарт бүртгэлтэй байна.

Хоршоодын дийлэнх нь хөдөө аж ахуйн (31.1%) болон худалдааны салбар (29.8%)-т байна. Харин хоршооны хувь нийлүүлсэн хөрөнгийн 52.9 хувь нь санхүү, даатгалын салбарт ногдож байна.

Хоршооны гишүүдийн дийлэнх нь худалдаа (39.3%), санхүү, даатгал (35.4%), хөдөө аж ахуйн (13.8%) салбарын хоршоодод гишүүнээр элссэн байна.



ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1

ХҮСНЭГТ 1.1. Монгол Улсын “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай” хуулийн дагуу ЖДҮҮЭ-д хамаарахгүй салбаруудын жагсаалт, ЭЗҮАСА-ийн дагуу

| № | ЭЗБҮАСА | |
|----|---------|--|
| | Анги | Тодорхойлолт |
| | | ХӨДӨӨ АЖ АХУЙН, ОЙН АЖ АХУЙ, ЗАГАС БАРИЛТ, АН АГНУУР |
| 1 | 0115 | Тамхины ургамал тариалалт УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ |
| 2 | 0510 | Чулуун нүүрс олборлолт |
| 3 | 0520 | Хүрэн нүүрс олборлолт |
| 4 | 0610 | Газрын түүхий тос олборлолт |
| 5 | 0620 | Байгалийн хий олборлолт |
| 6 | 0710 | Төмрийн хүдэр олборлолт |
| 7 | 0721 | Уран, торийн хүдэр олборлолт |
| 8 | 0729 | Бусад өнгөт төмөрлөгийн хүдэр олборлолт |
| 9 | 0810 | Чулуу, элс, шороо олборлолт |
| 10 | 0891 | Химийн аж үйлдвэр, бордооны үйлдвэрлэлд зориулсан эрдсийн түүхий эд, хүдэр олборлолт |
| 11 | 0892 | Хүлэр олборлолт |
| 12 | 0893 | Давс, шүү олборлолт |
| 13 | 0899 | Дээрх ангид ороогүй бусад ашигт малтмалын олборлолт |
| 14 | 0910 | Газрын түүхий тос, байгалийн хий олборлолттой холбогдох туслах үйл ажиллагаа |
| 15 | 0990 | Уул уурхайн туслах үйл ажиллагаа БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ |
| 16 | 1101 | Спирт нэрэх, цэвэршүүлэх, спиртийн хольц бэлтгэх үйлдвэрлэл |
| 17 | 1102 | Дарс үйлдвэрлэл |
| 18 | 1103 | Шар айраг үйлдвэрлэл |
| 19 | 1104 | Согтууруулах бус ундааны үйлдвэрлэл; савласан рашаан, бусад усны үйлдвэрлэл |
| 20 | 1200 | Тамхи үйлдвэрлэл |
| 21 | 1910 | Коксын зууханд боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл |
| 22 | 1920 | Боловсруулсан газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл |
| 23 | 2100 | Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл |
| 24 | 2410 | Төмөр болон ган үйлдвэрлэл |
| 25 | 2420 | Үнэт болон төмөрлөг бус бусад металл үйлдвэрлэл |
| 26 | 2431 | Төмөр болон гангийн цутгамал үйлдвэрлэл |
| 27 | 2432 | Төмөрлөг бус металл цутгамал үйлдвэрлэл |
| 28 | 2520 | Зэр зэвсэг, цэргийн хэрэгсэл үйлдвэрлэл ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ |
| 29 | 3510 | Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл, дамжуулах, түгээх үйл ажиллагаа |
| 30 | 3520 | Хийн үйлдвэрлэл, хийн түлшиг хоолойгоор түгээх үйл ажиллагаа |
| 31 | 3530 | Уур, агааржуулагчийн хангамжийн үйл ажиллагаа |
| | | УС ХАНГАМЖ; СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА |
| 32 | 3600 | Ус хуримтлуулах, ариутгах, түгээх үйл ажиллагаа |
| 33 | 3700 | Сувагжилтын систем |

ХАВСРАЛТ 1.1-ийн үргэлжлэл.

| № | ЭЗБТҮАСА | |
|----|----------|---|
| | Анги | Тодорхойлолт |
| | | БАРИЛГА |
| 34 | 4210 | Төмөр зам болон авто замын байгууламж барих үйл ажиллагаа БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА; МАШИН, МОТОЦИКЛИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ |
| 35 | 4730 | Шатахууны жижиглэн худалдаа ТЭЭВЭР, АГУУЛАХЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА |
| 36 | 4911 | Хот хоорондын төмөр замын зорчигч тээвэр |
| 37 | 4912 | Төмөр замын ачаа тээвэр |
| 38 | 5011 | Далайн эрэг орчмын болон тэнгисийн зорчигч тээвэр |
| 39 | 5012 | Далайн эрэг орчмын болон тэнгисийн ачаа тээвэр |
| 40 | 5021 | Дотоодын усан замын зорчигч тээвэр |
| 41 | 5022 | Дотоодын усан замын ачаа тээвэр |
| 42 | 5110 | Агаарын зорчигч тээвэр |
| 43 | 5120 | Агаарын ачаа тээвэр |
| | | МЭДЭЭЛЭЛ, ХОЛБОО |
| 44 | 5912 | Кино зураг, видео дүрс бичлэг, телевизийн хөтөлбөрийг дахин боловсруулсны дараах шатны үйл ажиллагаа |
| 45 | 5913 | Кино зураг, дүрс бичлэг, телевизийн хөтөлбөрийг хуваарилан тархаах үйл ажиллагаа |
| 46 | 5914 | Кино зургийг дэлгэцэд үзүүлэх үйл ажиллагаа |
| 47 | 5920 | Дуу бичлэг, хөгжмийн эх бэлтгэх үйл ажиллагаа |
| 48 | 6010 | Радио нэвтрүүлгийг дамжуулах үйл ажиллагаа |
| 49 | 6020 | Телевизийн өргөн нэвтрүүлэг бэлтгэх болон дамжуулах үйл ажиллагаа |
| 50 | 6110 | Утсан холбоо |
| 51 | 6120 | Утасгүй холбоо |
| 52 | 6130 | Сансрын холбоо |
| 53 | 6190 | Цахилгаан холбооны бусад үйл ажиллагаа САНХҮҮГИЙН БОЛОН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА |
| 54 | 6411 | Төв банкны үйл ажиллагаа |
| 55 | 6419 | Мөнгөний зуучлалын бусад үйл ажиллагаа |
| 56 | 6420 | Холдинг компанийн үйл ажиллагаа |
| 57 | 6430 | Итгэлцэл, сангууд болон бусад ижил төстэй санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа |
| 58 | 6491 | Санхүүгийн лизингийн үйл ажиллагаа |
| 59 | 6492 | Зээл олгох бусад үйлчилгээ |
| 60 | 6499 | Дээрх ангид ороогүй даатгал, тэтгэврээс бусад санхүүгийн үйлчилгээ |
| 61 | 6511 | Амьдралын даатгал |
| 62 | 6512 | Амьдралын даатгалаас бусад даатгал |
| 63 | 6520 | Давхар даатгал |
| 64 | 6530 | Тэтгэврийн сан |
| 65 | 6611 | Санхүүгийн зах зээлийн удирдлага |
| 66 | 6612 | Үнэт цаас болон бараа бүтээгдэхүүний брокерын үйл ажиллагаа |
| 67 | 6619 | Санхүүгийн үйлчилгээний хувьд туслах болох бусад үйл ажиллагаа |
| 68 | 6621 | Эрсдэл, хохирлын үнэлгээ өгөх үйл ажиллагаа |
| 69 | 6622 | Даатгалын төлөөлөгч, зуучлагчийн үйл ажиллагаа |
| 70 | 6629 | Даатгал, тэтгэврийн санхүүжилтийн бусад туслах үйл ажиллагаа |
| 71 | 6630 | Хөрөнгө оруулалтын сангийн болон үнэт цаасны удирдлагын үйл ажиллагаа ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА |
| 72 | 6810 | Өөрийн болон лизингийн үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа |
| 73 | 6820 | Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгддэг үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа |

ХАВСРАЛТ 1.1-ийн үргэлжлэл.

| № | ЭЗБТҮАСА | |
|-----|----------|--|
| | Анги | Тодорхойлолт |
| | | МЭРГЭЖЛИЙН, ШИНЖЛЭХ УХААН БОЛОН ТЕХНИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА |
| 74 | 6910 | Хуулийн үйл ажиллагаа |
| 75 | 6920 | Бүртгэл, нягтлан бодох бүртгэл болон аудитын үйл ажиллагаа; татварын асуудлаар зөвлөгөө өгөх |
| 76 | 7110 | Архитектур, инженерийн үйл ажиллагаа болон холбогдох техникийн зөвлөх үйлчилгээ |
| | | УДИРДЛАГЫН БОЛОН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА |
| 77 | 7810 | Хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах албаны үйл ажиллагаа |
| 78 | 7820 | Ажил түр эрхлүүлэх агентлагийн үйл ажиллагаа |
| 79 | 7830 | Хүний нөөцөөр хангах болон хүний нөөцийн менежментийн үйл ажиллагаа |
| 80 | 8010 | Хувийн харуул хамгаалалтын үйл ажиллагаа |
| 81 | 8020 | Хамгаалалтын системээр хангах үйл ажиллагаа |
| 82 | 8030 | Мөрдөх үйл ажиллагаа |
| 83 | 8211 | Албан газрын удирдлагын үйл ажиллагаа |
| 84 | 8220 | Утасны дуудлагын төвийн үйлчилгээ |
| 85 | 8291 | Өр барагдуулах алба, зээлийн товчооны үйл ажиллагаа |
| | | ТӨРИЙН УДИРДЛАГА, БАТЛАН ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, АЛБАН ЖУРМЫН НИЙГМИЙН ХАМГААЛАЛ |
| 86 | 8411 | Төрийн удирдлагын үйл ажиллагаа |
| 87 | 8412 | Нийгмийн хамгааллаас бусад эрүүл мэнд, боловсрол, соёл урлагийн үйлчилгээ болон нийгмийн бусад үйлчилгээ |
| 88 | 8413 | Илүү үр ашигтай арилжааны үйл ажиллагааг үзүүлэх, зохицуулах, дэмжих |
| 89 | 8421 | Гадаад харилцааны үйл ажиллагаа |
| 90 | 8422 | Батлан хамгаалах үйл ажиллагаа |
| 91 | 8423 | Нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаа |
| 92 | 8430 | Нийгмийн хамгааллын албан журмын үйл ажиллагаа |
| | | БОЛОВСРОЛ |
| 93 | 8510 | Сургуулийн өмнөх болон бага боловсрол олгох |
| 94 | 8521 | Суурь болон бүрэн дунд боловсрол олгох |
| 95 | 8522 | Техник, мэргэжлийн дунд боловсрол олгох |
| 96 | 8530 | Дээд боловсрол олгох |
| 97 | 8541 | Спорт, чөлөөт цагт зориулсан боловсрол олгох |
| 98 | 8542 | Соёлын боловсрол олгох |
| 99 | 8549 | Дээр дурдсан ангид ороогүй боловсролын бусад үйл ажиллагаа |
| 100 | 8550 | Боловсролын туслах үйл ажиллагаа |
| | | УРЛАГ, ҮЗВЭР, ТОГЛООМ НААДАМ |
| 101 | 9200 | Мөрийтэй тоглоом зохион байгуулах, явуулах үйл ажиллагаа |
| | | ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА |
| 102 | 9411 | Бизнесийн болон ажил олгогчдын гишүүнчлэл бүхий байгууллагуудын үйл ажиллагаа |
| 103 | 9412 | Мэргэжлийн гишүүнчлэл бүхий байгууллагуудын үйл ажиллагаа |
| 104 | 9420 | Үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа |
| 105 | 9491 | Шашны байгууллагын үйл ажиллагаа |
| 106 | 9492 | Улс төрийн байгууллагын үйл ажиллагаа |
| 107 | 9499 | Дээрх ангид ороогүй гишүүнчлэл бүхий бусад байгууллагын үйл ажиллагаа |
| | | ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА, СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА |
| 108 | 9900 | Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа |

ХАВСРАЛТ 2

ХҮСНЭГТ 2.1. ХУУЛИЙН ЭТГЭЭД, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн эцэст

| Бүс, аймаг, нийслэл | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---------------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|
| БҮГД | 172 466 | 189 801 | 206 207 | 230 608 | 248 831 |
| Баруун бүс | 9 856 | 10 428 | 11 070 | 12 084 | 13 123 |
| Баян-Өлгий | 1 963 | 2 056 | 2 140 | 2 376 | 2 541 |
| Говь-Алтай | 1 153 | 1 212 | 1 290 | 1 410 | 1 554 |
| Завхан | 2 050 | 2 164 | 2 271 | 2 425 | 2 665 |
| Увс | 2 026 | 2 171 | 2 290 | 2 426 | 2 559 |
| Ховд | 2 664 | 2 825 | 3 079 | 3 447 | 3 804 |
| Хангайн бүс | 13 704 | 14 443 | 15 167 | 16 206 | 17 393 |
| Архангай | 1 548 | 1 649 | 1 636 | 1 760 | 1 920 |
| Баянхонгор | 1 797 | 1 939 | 2 101 | 2 288 | 2 491 |
| Булган | 1 540 | 1 621 | 1 726 | 1 853 | 2 011 |
| Орхон | 4 596 | 4 812 | 5 065 | 5 384 | 5 663 |
| Өвөрхангай | 1 908 | 2 016 | 2 121 | 2 250 | 2 431 |
| Хөвсгөл | 2 315 | 2 406 | 2 518 | 2 671 | 2 877 |
| Төвийн бүс | 15 369 | 16 476 | 17 633 | 18 915 | 20 535 |
| Говьсүмбэр | 472 | 494 | 559 | 594 | 637 |
| Дархан-Уул | 3 955 | 4 192 | 4 455 | 4 687 | 4 939 |
| Дорноговь | 1 607 | 1 767 | 1 942 | 2 118 | 2 324 |
| Дундговь | 1 064 | 1 124 | 1 174 | 1 228 | 1 336 |
| Өмнөговь | 2 660 | 2 942 | 3 238 | 3 650 | 4 064 |
| Сэлэнгэ | 3 379 | 3 569 | 3 721 | 3 911 | 4 152 |
| Төв | 2 232 | 2 388 | 2 544 | 2 727 | 3 083 |
| Зүүн бүс | 5 072 | 5 514 | 5 957 | 6 421 | 6 948 |
| Дорнод | 2 210 | 2 377 | 2 525 | 2 707 | 2 945 |
| Сүхбаатар | 1 059 | 1 130 | 1 199 | 1 282 | 1 391 |
| Хэнтий | 1 803 | 2 007 | 2 233 | 2 432 | 2 612 |
| Улаанбаатар | 128 465 | 142 940 | 156 380 | 176 982 | 190 832 |

ХҮСНЭГТ 2.2. ХУУЛИЙН ЭТГЭЭД, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, жил бүрийн эцэст

| Салбар | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|----------------|----------------|----------------|----------------|----------------|
| БҮГД | 172 466 | 189 801 | 206 207 | 230 608 | 248 831 |
| Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур | 7 964 | 8 499 | 9 171 | 9 975 | 11 086 |
| Уул уурхай, олборлолт | 2 656 | 2 765 | 2 865 | 2 964 | 3 072 |
| Боловсруулах үйлдвэрлэл | 11 418 | 12 506 | 13 660 | 14 876 | 16 217 |
| Цахилгаан, хий, уур, агааржуулалт | 344 | 358 | 356 | 357 | 365 |
| Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа | 293 | 313 | 327 | 357 | 401 |
| Барилга | 13 623 | 14 687 | 15 858 | 17 522 | 18 616 |
| Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ | 69 466 | 76 697 | 81 327 | 88 256 | 94 948 |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 3 630 | 4 121 | 4 697 | 6 045 | 6 973 |
| Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ | 4 402 | 4 730 | 5 211 | 5 753 | 6 335 |
| Мэдээлэл, холбоо | 4 352 | 4 973 | 5 607 | 6 591 | 7 215 |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 4 415 | 4 682 | 4 848 | 5 056 | 5 193 |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 1 913 | 2 089 | 2 203 | 2 263 | 2 336 |
